

ИНД-125

~~АГААРЫН ТЭЭВЭР – ДУНД АГААРЫН ХӨЛӨГ~~  
**НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА- ДУНД ОНГОЦ**

**/-Air operations / Нислэгийн үйл ажиллагаа/**

**Air transport / Агаарын тээвэр/**

- Aeroplane - онгоц
- Aircraft - агаарын хөлөг/

## ТОДОРХОЙЛОЛТ

ИНД-119-ийн дагуу **АТГ эзэмшигч агаарын тээвэрлэгчийн** /"Airline AOC" гэсэн утгыг гаргахгүй бол General Aviation AOC-ээс ялгагдахгүй болох гээд байна/ ашиглаж буй агаарын хөлөгт дараахь нөхцлүүд тохирч байгаа бол үйл ажиллагаанд нь тавих шаардлагыг ИНД-125-аар зохицуулна. Үүнд:

1. Зорчигчийн суудал 10-30, эсвэл
2. Төлбөртэй ачаалалтын /төлбөрт ачаалал гэхүү/ хэмжээ 3410 кг бөжөн **эсхүл** түүнээс бага, мөн хөөрөлтийн хамгийн их жин нь 5700кг-аас их, эсвэл
3. Агаарын хөлөг нь ганц хөдөлгүүртэй бөгөөд ХНД-ээр зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэх бол.

Энэ ангилалын **агаарын хөлөг хэрэглэгчдэд** /агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчдэд/ тавих шаардлагыг нэг стандартад оруулснаар дараахь үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулах зорилготой болно. Үүнд:

- Агаарын тээвэр эрхлэгч хувь хүн
- Агаарын тээвэр эрхэлж буй АТГ эзэмшигч
- Агаарын тээвэр хийж буй агаарын хөлгийн дарга
- Зорчигч тээврийг, ХНД-ийн дагуу, ганц хөдөлгүүрт хөлгөөр хийх
- Агаарын хөлгийн нэмэлт төхөөрөмж, хэрэглэл мөн гэрчилгээжүүлэлтийн шаардлага болон үйл ажиллагааны тодорхойлолт
- Агаарын хөлгийн техник үйлчилгээ
- Багийн гишүүдийн сургалт, дадлага
- Нисэх багийн ажил, амралтын цагын зохицуулалт зэрэг болно.

## ~~Үгийн тайлбар, орчуулга, дүйцүүлэн товчилсон монгол хувилбар~~

<b>ATC</b>	- Нислэгийн Хөдөлгөөний Үйлчилгээ <b>/НХҮ/</b>
<b>AEDRS-</b>	<b><i>/automatic engine data recording system-</i></b> means a system that acquires data from specialised sensors that measure various parameters related to the airworthy condition of an aircraft engine/ - хөдөлгүүрийн өгөгдөхүүнийг автоматаар бичигч систем /цаашид товчлон хөдөлгүүрийн үзүүлэлт бичигч автомат буюу ХҮБА гэх/
<b>IFR</b>	- Хэрэглэлийн нислэгийн дүрэм / цаашид товчлон хэрэглэлийн нислэг буюу ХНД гэх/
<b>Flight path</b>	- Нислэгийн траектор
<b>Glade slope</b>	- глиссад
<b>Net flight path</b>	- Нислэгийн хийсвэр траектор
<b>RESA</b>	- <b><i>/runway end safety area/-</i></b> Хөөрч буух зурвас <b>/ХБЗ/-</b> ны төгсгөлийн аюулгүйн зурвас
<b>SARTIME</b>	- Дараагийн үйлдэлд шилжихээр нисгэгчийн зүгээс төлөвлөсөн цаг. (Өндөр алдах тооцоот цаг, буултын оролт үйлдэх тооцоот цаг, буух тооцоот цаг г.м)
<b>SEIFR</b>	- Ганц хөдөлгүүрт агаарын хөлгөөр хэрэглэлийн нисэлгийн дүрмээр үйлдэх нислэг /цаашид товчлон ганц хөдөлгүүртийн хэрэглэлийн нислэг буюу <b>ГХХН</b> гэх/
<b>VFR</b>	- Ил харааны нислэгийн дүрэм /цаашид товчлон ил харааны нислэг буюу ИХНД гэх/
<b>Must</b>	- үүрэгтэй байх <b>/тэгнэ ингэнэ</b> эсвэл <b>заавал</b> гэсэн захиран тушаах дээд хэлбэр/
<b>Should</b>	- тэгвэл зохино, ингэвэл зохино
<b>Shall</b>	- ёстой

## Дүрмийн шаардлагын жагсаалт **Гарчиг**

### БҮЛЭГ 1- ЕРӨНХИЙ

- 125.1 Ерөнхий .....
- 125.3 Тодорхойлолтууд.....
- 125.5 Хууль, дүрэм журмууд .....
- 125.7 Журманд нийцүүлэх .....
- 125.9 Дүрмийн шаардлагаас чөлөөлөх .....
- 125.11 Ганц хөдөлгүүрт агаарын хөлгөөр зорчигч тээвэр хийх.....

### БҮЛЭГ 2- НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 125.51 Нөөцөлсөн .....
- 125.53 Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар .....
- 125.54 ГХХН-ийн баталгаажуулах нислэг .....
- 125.55 Нийтлэг хэл .....
- 125.57 Нислэгт бэлдэх .....
- 125.58 Эрэн хайх, аврах ажиллагаанд шаардлагатай мэдээлэл .....
- 125.59 Аврах болон онцгой тохиолдлын үед ашиглах төхөөрөмжийн талаархи мэдээлэл .....
- 125.61 Түлш .....
- 125.63 Нислэгт шалгах тогтолцоо .....
- 125.65 Зорчигчийн талаархи аюулгүй ажиллагаа .....
- 125.67 Нисгэгчийн бүхээгт орох эрх .....

125.69	Жолоо, удирдлагын зохицуулалт .....
125.71	Нислэгийн өгөгдөхүүн бичигчийн талаархи шаардлагууд .....
125.72	ХҮБА/AEDRS/-ийн ашиглалтын шаардлагууд .....
125.73	Түлшээр сумлах болон соруулах ажиллагаа.....
125.75	Нөөцөлсөн.....
125.77	Аэродром ашиглалт .....
125.79	Ганц хөдөлгүүрт агаарын хөлгөөр үйлдэх зорчигч тээвэр.....
125.81	Ганц хөдөлгүүрт агаарын хөлгийн ашиглалт – ХНД .....
125.83	Үйл ажиллагааны эрхийг цуцлах эсвэл хориг тавих .....
125.85	Ил харааны /ИХД/ нислэгийн хамгийн бага жинхэнэ өндөр .....
125.87	Усан дээгүүрх нислэг .....
125.89	Шөнийн нислэг .....
125.91	Онцгой тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө .....
125.93	ГХХН – хөдөлгүүрийн өгөгдөхүүн эсвэл ХҮБА хэвийн бус үед нэн даруй авах арга хэмжээ.....
125.95	ГХХН – бүсийн навигацийн тоноглолд тавих шаардлага .....

### БҮЛЭГ 3 – АШИГЛАЛТЫН ХЯЗГААРЛАЛТУУД БОЛОН ЦАГ АГААРЫН ШААРДЛАГА

125.151	Ерөнхий .....
125.153	Цаг уурын мэдээ .....
125.155	Цаг агаарын нөхцөл – Ил харааны нислэг .....
125.157	Цаг агаарын нөхцөл – Хэрэглэлийн нислэг .....
125.159	Аэродромын минимум – Хэрэглэлийн нислэг .....
125.161	ХНД-ээр нисэн гарах хязгаарлалтууд .....

125.163 Хөөрөлтийн минимумыг багасгасах.....

125.165 ХНД-ийн журам .....

#### БҮЛЭГ 4- АГААРЫН ХӨЛГИЙН АШИГЛАЛТ

125.201 Ерөнхий .....

125.203 Нөөцөлсөн .....

125.205 ИНД-121-ийн Бүлэг Г-ийн шаардлагыг хангасан байдал .....

125.207 Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн ашиглалт .....

125.209 Хөөрөлтийн дистанц .....

125.211 ХБЗ-ийн гадаргуу болон зурвасны налууугын нөлөөг тооцох .....

125.213 Хөөрөлтийн үедэх нислэгийн хийсвэр траектор – ХНД-ээр нисэж буй агаарын хөлгийнх .....

125.215 Хөдөлгүүр татгалзсан – унах хурдны итгэлцүүр ба түүнд засвар оруулан тооцох .....

125.217 Маршрутанд – критик эрсдэлтэй хөдөлгүүр татгалзах .....

125.219 Маршрутанд – 90 минутын хязгаарлалт.....

125.221 Буулт – Өндөр авалт – зорьсон газар болон бэлтгэл аэродромууд

125.223 Буултын диетанц зай– хуурай зурвас .....

125.225 Буултын диетанц зай – Бохирдолттой болон нойтон зурвас .....

125.227 Огцом оролт болон түүнчлэн буулт үйлдэх аргачлал .....

125.228 FAR-23-аар гэрчилгээжсэн богино зайн (орон нутгын) агаарын хөлөг ба SFAR-41-ээр гэрчилгээжсэн агаарын хөлөг .....

125.229 Хөөрөлтийн диетанц.....

125.231 Хөөрөлтийн үе дэх нислэгийн хийсвэр траектор.....

- 125.233 Буултын диетанц зай– хуурай зурвас .....
- 125.235 Буултын диетанц зай – нойтон болон Бохирдолттой зурвас .....

#### БҮЛЭГ 5 – ЖИН ТӨВЛӨРӨЛТ

- 125.301 Ерөнхий.....
- 125.303 Эд зүйлс, зорчигч болон тээшний жин.....
- 125.305 Агаарын хөлгийн ачаалалтын хязгаарлалт.....
- 125.307 Ачаалалтын хуудас.....

#### БҮЛЭГ 6 – ХЭРЭГЛЭЛ БОЛОН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

- 125.351 Ерөнхий.....
- 125.353 Ерөнхий.....
- 125.355 Суудал болон суудлын бүс.....
- 125.357 Нэмэлт хэрэглэл .....
- 125.359 Шөнийн нислэг .....
- 125.361 Хэрэглэлийн нислэгийн дүрэм .....
- 125.363 Онцгой тохиолдолын тоног төхөөрөмж .....
- 125.364 Амьсгалын хамгаалах хэрэгслэл .....
- 125.365 Зарлан мэдээлэх болон багийн дотоод холбооны тоноглол .....

- 125.367 Бүхээгийн яриа бичигч .....
- 125.369 Нислэгийн өгөгдөхүүн бичигч .....
- 125.371 Нэмэлт авиагоризонт .....
- 125.373 Хөлгийн локатор .....
- 125.375 Газар ойртсныг анхааруулах систем.....
- 125.377 ХҮБА /AEDRS/ .....
- 125.379 Саадаас хамгаалах буюу анхааруулах систем .....
- 125.381 Агаарт мөргөлдөхөөс сэргийлэх систем .....

#### БҮЛЭГ 7 – ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭ

- 125.401 Ерөнхий .....
- 125.403 Нислэгт тэнцэх чадварын талаар хүлээх хариуцлага
- 125.405 Техник үйлчилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах
- 125.407 Техник үйлчилгээний хөтөлбөр – ХҮБА бүхий агаарын хөлөгт хамаарах нэмэлт шаардлага
- 125.409 Нөөцөлөөн
- 125.411 Нөөцөлөөн
- 125.413 Нөөцөлөөн
- 125.415 Техник үйлчилгээний тойм /maintenance review/
- 125.417 Шилжилтийн үе – Техник үйлчилгээний хөтөлбөр – ХҮБА бүхий агаарын хөлөгт хамаарах нэмэлт шаардлага

#### БҮЛЭГ 8 – НИСЭХ БАГИЙН ГИШҮҮДЭД ХАМААРАХ ШААРДЛАГА

- 125.501 Ерөнхий



- 125.503 Нисэх багийн гишүүнээр томилох
- 125.505 Тухайн агаарын хөлгийн маяг дээр хөлгийн даргаар ниссэн туршлагад тавих шаардлага
- 125.507 Агаарын хөлгийн даргын ИХНД-ээр ниссэн дадлага туршлагад тавих шаардлага
- 125.509 Агаарын хөлгийн даргын ХНД-ээр ниссэн дадлага туршлагад тавих шаардлага
- 125.511 Багш нисгэгчийн дадлага туршлагад тавих шаардлага
- 125.513 Шалгагч нисгэгчийн дадлага туршлагад тавих шаардлага
- 125.515 Агаарын хөлгийн үйлчлэгчийн дадлага туршлагад тавих шаардлага
- 125.517 Нислэгийн дадлагажуурын багш болон шалгагчийн дадлага туршлагад тавих шаардлага
- 125.519 Агаарын хөлгийн багш үйлчлэгчийн дадлага туршлагад тавих шаардлага
- 125.521 Агаарын хөлгийн шалгагч үйлчлэгчийн дадлага туршлагад тавих шаардлага
- 125.523 Газарт багшлагчийн дадлага туршлагад тавих шаардлага
- 125.525 Нисэх багийн гишүүдийн тооны хязгаарлалт – Хэрэглэлийн нислэг
- 125.527 Нисэх багийн гишүүдийг томилохдоо харгалзах зүйлс
- 125.529 Нэгээс олон төрөл болон маяг дээр нисдэг нисгэгч
- 125.531 Хөөрөлтийн багасгасан минимум болон CAT II эсвэл III – ийн эрх бүхий нисгэгч
- 125.533 Шилжилтийн үеийн зохицуулалт

## БҮЛЭГ 9 – СУРГАЛТ ДАДЛАГА

125.551 Ерөнхий

- 125.553 Багийн гишүүдийн сургалтын хөтөлбөр
- 125.555 Багийн гишүүдийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэглэх тоног төхөөрөмж
- 125.557 Багийн гишүүний анхан шатны сургалт
- 125.559 Багийн гишүүнийг шилжүүлэх сургалт
- 125.561 Багийн гишүүнийг дэвшүүлэх сургалт
- 125.563 Багийн гишүүний давтан сургалт
- 125.565 Нисэх багийн сургалтын төхөөрөмж
- 125.567 Нисгэгчийн шугамын нислэг дэх сургалт – Зөөлтийн нислэг
- 125.569 Агаарын хөлгийн үйлчлэгчийн сургалтын хөтөлбөр
- 125.571 Агаарын хөлгийн үйлчлэгчийн дадлага туршлага
- 125.573 Сургалтын бичиг баримт
- 125.575 Шилжилтийн үеийн үеийн зохицуулалт

#### БҮЛЭГ-10 – БАГИЙН ГИШҮҮДИЙН УР ЧАДВАРЫН ХАДГАЛАЛТ

- 125.601 Зорилго
- 125.603 Ерөнхий
- 125.605 Ур чадварын үнэлгээний хөтөлбөрийн талаар хүлээх хариуцлага
- 125.607 Нисэх багийн гишүүний ур чадварын үнэлгээ
- 125.609 Багш нисгэгч, дадлагажуурын багш болон нислэгийн шалгагчийн ур чадварын үнэлгээ
- 125.611 Агаарын хөлгийн үйлчлэгчийн ур чадварын үнэлгээ
- 125.613 Ур чадварын үнэлгээ болон шалгалтын баримт бичиг
- 125.615 Шилжилтийн үеийн зохицуулалт

#### БҮЛЭГ-11– НИСЭХ БАГИЙН АЖИЛ АМРАЛТЫН ЦАГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

- 125.801 Зорилго
- 125.803 Хэрэглэгчийн хүлээх хариуцлага
- 125.805 Нисэх багийн хүлээх хариуцлага

#### БҮЛЭГ-12– ЗААВАР, БҮРТГЭЛ БОЛОН БАРИМТ БИЧИГ

- 125.851 Зорилго
- 125.853 Эрхлэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл

- 125.855 Агаарын хөлөгт байх ёстой баримт бичгүүд
- 125.857 Үйл ажиллагааны баримтын хөтлөлт
- 125.859 Баримт бичгийг хадгалах
- 125.861 ХҮБА/AEDRS/-ийн хөтлөлт

#### ХАВСРАЛТ А - Нөөцөлсөн

#### ХАВСРАЛТ Б – ХЭРЭГЛЭЛ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТАЛААРХ НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАРЫН СТАНДАРТ

- Б.1 – Зарлан мэдээлэх систем
- Б.2 – Багийн гишүүдийн дотоод холбооны систем
- Б.3 – Бүхээгийн яриа бичигч
- Б.4 – Нислэгийн өгөгдөхүүн бичигч
- Б.5 – Нэмэлт өндрийн хэрэглэл
- Б.6 – Хөлгийн локатор
- Б.7 – Газар ойртсныг анхааруулах систем
- Б.8 – ХҮБА /AEDRS/
- Б.9 – Саадаас сэргийлэх буюу анхааруулах систем /TAWS/
- Б.10 - Агаарт мөргөлдөхөөс сэргийлэх систем /ACAS II/
- Б.11 - Амьсгалын хамгаалах хэрэгслэлүүд

Хүснэгт - 1

Хүснэгт – 2

#### ХАВСРАЛТ В – ХӨӨРЧ БУУХ ЗУРВАС /ХБЗ/

В.1 - ХБЗ- ийн өргөний талаарх хязгаарлалтууд

В.1.1 - Хүснэгт – 1. Аэродромын итгэлцүүр /ARC/-ийг тодорхойлох

В.1.2 - Хүснэгт – 2. ХБЗ-ийн зөвшөөрөгдөх өргөнийг тодорхойлох

В.1.3 - Нөөцөлсөн

#### Дүрмийн шаардлагын жагсаалт

Үгийн тайлбар, орчуулга, дүйцүүлэн товчилсон монгол хувилбар.....	3
БҮЛЭГ – 1 – ЕРӨНХИЙ.....	12
125.3 Тодорхойлтууд.....	12
125.5 Хууль, дүрэм болон журам.....	13
125.7 Журмын мөрдөлт.....	13
125.8 Хугацаандаа гүйцэтгэсэнд тооцох тухай.....	13

125.9	Шаардлагаас чөлөөлөх.....	13
125.11	ГХХН-ийн дагуу зорчигч тээвэрлэх.....	13
БҮЛЭГ – 2 – НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....		14
125.51	Нөөцөлсөн.....	14
125.53	Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар.....	14
125.54	ГХХН-ийн батлах нислэг.....	15
125.55	Нийтлэг хэл.....	15
125.57	Нислэгт бэлдэх.....	15
125.58	Эрэн хайх авран хамгаалахад шаардлагатай мэдээлэл.....	16
125.59	Аврах буюу онцгой тохиолдолд хэрэглэх тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл.....	16
125.61	Түлш 17	
125.63	Нислэгийн хянан нягтлах тогтолцоо.....	18
125.65	Зорчигч – Аюулгүй ажиллагаа.....	19
125.67	Нисгэгчийн бүхээгт нэвтрэх.....	20
125.69	Агаарын хөлгийн жолоо удирдлагаар оролдох.....	20
125.71	Нислэгийн үзүүлэлт бичигчийн талаарх шаардлага.....	21
125.72	ХҮБА/AEDRS-үйл ажиллагааны шаардлага.....	22
125.73	Түлшээр цэнэглэх болон соруулах ажиллагаа.....	22
125.75	Нөөцөлсөн.....	23
125.77	Аэродром ашиглалт.....	23
125.79	ГХХН –Зорчигч тээвэр.....	25
125.81	Гагц хөдөлгүүртэй агаарын хөлгийн үйл ажиллагаа – ХНД.....	27
125.83	Үйл ажиллагааг хязгаарлах эсвэл түтгэлзэх.....	27
125.85	ИХНД-ийн өндрийн минимум.....	27
125.87	Усан дээгүүрх нислэг.....	27
125.89	Шөнийн ниислэгийн үйл ажиллагаа.....	27
125.91	Онцгой тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө.....	28

125.93	ГХХН – Хөдөлгүүрийн үзүүлэлт эсвэл AEDRS.....29 хэвийн бус үед авах арга хэмжээ.....	29
125.95	ГХХН – Бүсийн навигацийн тоноглолын системийн талаарх шаардлага .....	30
<b>БҮЛЭГ 3 – АШИГЛАЛТЫН ХЯЗГААРЛАЛТУУД БОЛОН ЦАГ УУРЫН ШААРДЛАГА</b>		
125.151	Зорилго .....	30
125.153	Цаг уурын мэдээ.....	30
125.155	Цаг агаарын нөхцөл – ИХНД-ийн нислэг.....	31
125.157	Цаг агаарын нөхцөл – ХНД-ийн нислэг.....	33
125.159	Аэродромын минимум – ХНД-ийн нислэг.....	33
125.161	ХНД-ээр нисэн гарах хязгаарлалт.....	34
125.163	Хөөрөлтийн багасгасан минимум.....	34
125.165	ХНД-ийн журмууд.....	35
<b>БҮЛЭГ 4 – АШИГЛАЛТ</b> .....		
125.201	Зорилго .....	36
125.203	Нөөцөлсөн.....	36
125.205	ИНД-125-ийн Бүлэг Г – ийн шаардлага хангасан байдал.....	36
125.207	Агаарын хөлгийн ерөнхий ашиглалт.....	36
125.209	Хөөрөлтийн дистанц.....	37
125.211	ХБЗ-ийн гадаргуу болон зурвасны налуугын нөлөөг тооцох.....	37
125.213	Хөөрөлтийн хийсвэр траектор- ХНД-ийн агаарын хөлөг.....	38
125.215	Хөдөлгүүр татгалзах – градиент болон унах хурдны засвар.....	40
125.217	Маршрутанд – критик хөдөлгүүр татгалзах.....	41
125.219	Маршрутанд – 90 минутын хязгаарлалт.....	41
125.221	Буултын-өндөр авалт – Очих газар болон бэлтгэл аэродром.....	42
125.223	Буултын дистанц – хуурай ХБЗ.....	43

## **БҮЛЭГ – 1 – ЕРӨНХИЙ**

### **125.1 Зорилго**

- а) Энэ зүйлийн (b)-г харгалзан, доорх үзүүлэлт бүхий хөлөг ашиглан агаарын тээвэр эрхлэх үйл ажиллагааг зохицуулах журмыг тогтооход энэхүү дүрмийн зорилго оршино:
- 1) 10-аас 30 хүртэл зорчигчийн суудалтай; эсвэл
  - 2) Хөөрөлтийн хамгийн их жин нь 5700кг-ээс их эсвэл төлбөртэй ачаалалтын хэмжээ нь 3410 буюу түүнээс бага; эсвэл
  - 3) ГХХН /SEIFR/-ээр зорчигч тээвэр хийж байгаа бол.
- б) Хэрэв зорчигчийн суудлын тоо эсвэл төлбөртэй ачааллын хэмжээний аль нэг нь ИНД-121-д хамаарахаар бол үйл ажиллагааг ИНД-121-ийн дагуу явуулах ёстой.

### **125.3 Тодорхойлтууд**

**Нислэгийн үйл ажиллагаа /Air operation/** гэдэг нь дараахь төрлийн аль нэгийн дагуу агаарын тээвэр эсвэл ашгийн төлөөх /комерийн/ тээврийн үйл ажиллагаа эрхлэхийг хэлнэ. Үүнд:

- 1) хөөрөлтийн хамгийн их жин нь 5700 кг-аас их эсвэл төлбөртэй ачаалалтын хэмжээ нь 3410 кг буюу түүнээс бага эсвэл багийн гишүүдэд шаардлагатай суудлыг оролцуулан, 10-аас 30 хүртэл хүний суудалтай агаарын хөлөг ашиглаж; эсвэл
- 2) Ганц хөдөлгүүрт агаарын хөлгөөр, ХНД-ийн дагуу /ГХХН/ зорчигч тээвэр эрхэлж байгаа бол.

**Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ /AOC/** гэж, агаарын шугаманд нислэгийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээг хэлнэ.

**Байгууллагын ерөнхий заавар /Exposition/** гэж, өөр эх үүсвэрийг дурьдаагүй тохиолдолд ИНД-119.81 эсвэл ИНД-119.125- аар шаардсан мэдээллийг агуулсан бичиг баримтыг хэлнэ.

**Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч** гэж, ИНД-119-ийн дагуу агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ авсан нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийг хэлнэ.

**Хөөрөлтийн нислэгийн хийсвэр траектор, хөөрөлтийн нислэгийн траектор, хөөрөлтийн дистанц болон хөөрөлтийн гүйлтийн урт** гэх мэт ойлголтууд нь тухайн агаарын хөлгийг гэрчилгээжүүлсэн дүрмэнд заасантай ижил утгатай болно.

**Зурвасны босго** гэж, буултын оролт үйлдэхэд зориулсан, 1:20-ийн хэмжээтэй ямар нэг саад байхгүй газрын гадаргуу явсаар ХБЗ-тай уулзах хэсгийг хэлнэ.

#### **125.5 Хууль, дүрэм болон журам**

Иргэний Нисэхийн тухай Хууль, Иргэний нисэхийн багц дүрэм болон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааврын зохих журмуудыг, ажилтнаар авсан, гэрээлсэн г.м ер нь үйл ажиллагаанд нь оролцож байгаа бүх хүмүүс уншиж танилцсан байхыг АТГ эзэмшигч бүр хангах ёстой.

#### **125.7 Журмын мөрдөлт**

Нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа хүн бүрийн үйлдэл нь, АТГ эзэмшигчийн, нислэгийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгож буй Үйл ажиллагааны зааварт заасан зохих журмын дагуу байх ёстой.

#### **125.8 Хугацаандаа гүйцэтгэсэнд тооцох тухай**

Багийн гишүүн нь, энэхүү дүрмийн Бүлэг – 9; 10 эсвэл **13 (М)** –д шаардсан, шалгалт, нислэгийн шалгалт эсвэл ур чадварын үнэлгээг дүрмэнд заасан хугацаа дуусах өдрөөс өмнөх 60 хоногын дотор хийлгэсэн бол түүнийг нь дүрмэнд заасан хугацаандаа гүйцэтгэсэн гэж тооцно.

#### **125.9 Шаардлагаас чөлөөлөх**

Энэхүү дүрмэнд заасан ХҮБА /AEDRS/-ийн тухай шаардлагаас чөлөөлөх ямарваа нэг баталгааг ИНЕГ-ийн зүгээс гаргахгүй байж болно.

#### **125.11 ГХХН-ийн дагуу зорчигч тээвэрлэх**

Хэрэв дараахь шаардлагыг хангаагүй бол АТГ эзэмшигч ямар ч этгээд ГХХН-ээр зорчигч тээвэрлэх ёсгүй:

- 1) ИНД-119.15(b)-(5)-ийн дагуу олгосон, АТГ-ний Хавсралт-Үйл ажиллагааны Тодорхойлолтонд нь “ГХХН-ийн дагуу зорчигч тээвэрлэх эрхтэй” гэж заасан; мөн
- 2) Энэхүү дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа; мөн
- 3) Үйл ажиллагаандаа ашиглаж буй агаарын хөлөг нь нисэх багийн гишүүдэд шаардлагатай суудлыг оролцуулан 14 буюу түүнээс цөөн суудалтай, мөн төлбөртэй ачаалалтын хэмжээ нь 3410 кг болон түүнээс бага бол.

## **БҮЛЭГ – 2 – НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **125.51 Нөөцөлсөн**

### **125.53 Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар**

- a) АТГ эзэмшигч бүрийн, гэрчилгээнд заасан эрхийнхээ дагуу нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж буй агаарын хөлөг бүр нь стандарт ангилалын нислэгт тэнцэх чадварын хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх ёстой.
- b) АТГ эзэмшигч бүр нь дараахь үүрэгтэй:
  - 1) Гэрчилгээгээр олгогдсон эрхийн дагуу, ГХХН-ийн дагуу зорчигч тээвэрлэх нислэгт ашиглаж буй агаарын хөлөг бүр нь, дараахь нөхцлийг хангаж ИКАО-ийн гишүүн аль нэг орноор гэрчилгээжсэн байна. Үүнд:
    - i. Турбинт хөдөлгүүртэй агаарын хөлгийн хувьд; мөн
    - ii. Хэрэглэлийн нислэгт зориулсан; мөн
    - iii. Наад зах нь FAR-23-ийн Өөрчлөлт-28 буюу түүнтэй дүйцэхүйц нислэгт тэнцэх чадварын стандартыг хангасан
  - 2) Сэнсний модель, хөдөлгүүрийн модель зэрэг сэнст болон хөдөлгүүрт агаарын хөлгийн найдвартай ажиллагааг хангаж буй, (b)(1)-д заасан эд ангиуд нь наад зах нь:
    - i. Маягийн хувьд ижил агаарын хөлөг дээр дор хаяж 100'000 **/hours time-in-service/** цагийн ашиглалтын хугацаатай ажилласан; мөн
    - ii. Сэнс, хөдөлгүүр болон бусад эд ангийн хувьд тухайн агаарын хөлөгт агаарын хөлөгт цуглуулан суурилуулсан хувилбарын хувьд агаарт хөдөлгүүр өөрөө татгалзсан тохиолдол 100'000 цаг тутамд нэгээс ихгүй.



#### 125.54 ГХХН-ийн батлах нислэг

- а) Хэдийгээр энэ тухай ИНД-119.57-ийн (а)-д заасан байгаа ч гэсэн, ИНД-119.15-ийн (а)-ийн (5)-д заасан АТГ-ний Хавсралт-Үйл ажиллагааны Тодорхойлолтонд өмнө нь, ГХХН-ийн дагуу зорчигч тээвэрлэх тухай заагаагүй бол тухайн үйл ажиллагааны эрхийг авахаар өргөдөл гаргаж буй АТГ эзэмшигч нь, энэхүү дүрмийн холбогдох шаардлагуудыг хангаж байгаагаа ИНЕГ-т үзүүлэх зорилгоор батлах нислэг болон туршилтанд хамрагдах ёстой.
- б) Энэхүү бүлгийн (а)-д заасан батлах нислэг болон туршилтыг ИНЕГ-ээс хүлээн зөвшөөрхүйц түвшинд гүйцэтгэх ёстой.

#### 125.55 Нийтлэг хэл

Гэрчилгээжсэн аливаа агаарын тээвэрлэгч нь дараахь нөхцлийг хангасан байх ёстой:

- 1) Багийн бүх гишүүд нийтлэг нэг хэлээр ойлголцох боломжтой байх бөгөөд тэдний ядаж нэг нь монгол хэлээр ойлголцох чадвартай байна; мөн
- 2) Хүн бүрийн ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой хэсэг нь, гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааварт тухайн ажилтны ойлгох хэл дээр бичигдсэн байна.

#### 125.57 Нислэгт бэлдэх

- а) АТГ эзэмшигч нь, тухайн гэрчилгээгээр олгогдсон эрхийн дагуу хийх гэж буй нислэг бүрийнхээ өмнө уг нислэгт бэлдэхэд шаардлагатай мэдээллээр агаарын хөлгийн даргыг заавал хангана.
- б) АТГ эзэмшигч нь, тухайн гэрчилгээгээр олгогдсон эрхийн дагуу гүйцэтгэх гэж буй нислэг бүрийнхээ өмнө нислэгийн төрлөөс хамаарч ИНД-91.307 эсвэл ИНД-91.407-ын дагуу нислэгийн төлөвлөгөө/**flight plan**/-г заавал бэлдэх бөгөөд хэрэв уг нислэгийг гүйцэтгэх агаарын хөлгийн дарга тухайн нислэгийн төлөвлөгөөг бэлдэхэд биечлэн оролцоогүй бол нислэгийн төлөвлөгөөнд тусгасан зүйлсийнхээ талаар агаарын хөлгийн даргад нислэг эхлэхээс өмнө мэдэгдсэн байна.
- с) ИНД-91.307-ийн шаардлагыг хангасан Ил харааны нислэгийн төлөвлөгөөг дээрх (b) заалтын дагуу бэлдэж гаргахдаа, буулт үйлдэх дараагийн аэродромын SARTIME-д нислэг үргэлжлэх хугацааг тооцон засвар оруулсан бол агаарын замын хэд хэдэн хэсгүүдийг нэгтгэхийг зөвшөөрнө.

- d) ИНД-91.307-д зааснаас үл хамаарч энэхүү бүлгийн (е) хэсэгт зааснаас бусад тохиолдолд, АТГ эзэмшигч нь (b)-д заасан нислэгийн төлөвлөгөөг нислэг бүрийн өмнө, НХҮ-ний зохих нэгжид заавал хүргүүлнэ.
- e) ИНД-91.307 болон ИНД-91.407- д зааснаас үл хамаарч, (d)-д заасан нислэгийн төлөвлөгөөг АТГ эзэмшигчийн зүгээс хүргүүлж болох бөгөөд нислэгийн төлөвлөгөөнд тусгасан зүйлсийнхээ талаар агаарын хөлгийн даргад заавал мэдэгднэ.
- f) ИХНД-ийн нислэгийн хувьд тухайн нислэг нь замдаа буухгүй бол НХҮ-ний нэгжид нислэгийн төлөвлөгөө өгөх шаардлагагүй гэхдээ:
  - 1) Тухайн нислэг нь хөөрсөн аэродромдоо эргэж бууснаар дуусгавар болж байгаа бөгөөд
  - 2) Нислэг аэродром орчимд 25nm /45км/-ийн дотор хийгдэх бол
- g) дээрх (е)-д дурьдсан нислэгийн хувьд НХҮ-ний нэгжид нислэгийн төлөвлөгөө хүргүүлэх шаардлагагүй боловч ИНД-119.73-д заасан, нислэгийн гүйцэтгэлийг хянах үйлчилгээ/flight following/-гээр заавал хангагдсан байна.

#### **125.58 Эрэн хайх авран хамгаалахад шаардлагатай мэдээлэл**

- a) Нислэг үйлдэж байгаа орон нутгийнхаа эрэн хайх, авран хамгаалах үйлчилгээний талаарх шаардлагатай мэдээллийг, АТГ эзэмшигчийн гэрчилгээгээр олгогдсон эрхийн дагуу ашиглаж буй агаарын хөлөг бүрт, авч явах ёстой.
- b) 2011 оны 9 сарын 30 хүртэл гэрчилгээ нь хүчин төгөлдөр байсан АТГ эзэмшигч нарыг дээрх (a)-ийн заалтаас чөлөөлөх бөгөөд энэ нь тухайн гэрчилгээний хугацаа дуусах өдөр эсвэл 2012 оны 4 сарын 01 өдөр хоёрын аль түрүүлж болох өдөр хүртэл үйлчилнэ. /A holder of an air operator certificate that was current on 30 September 2011 is not required to comply with the requirements of paragraph (a) until 1 April 2012 or until the holder's air operator certificate expires whichever is the sooner./

#### **125.59 Аврах буюу онцгой тохиолдолд хэрэглэх тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл**

- a) АТГ эзэмшигч бүр агаарын хөлөг бүрт байрлуулсан аврах болон онцгой тохиолдолын үед хэрэглэх тоног төхөөрөмжийн талаарх мэдээллийг, эрэн хайх авран хамгаалах үйл ажиллагааг зохицуулах төвд нэн даруй мэдээлэхэд бэлэн байлгах ёстой.

- b) Хэрэв аэродромоос 90 км/50 nm/ -ээс хол зайд нислэг үйлдэх бол дээрх (а)-д заасан мээдээлэлд дараахь мэдээллийг оруулах ёстой:
- 1) тоо, өнгө, мөн аврах завины төрөл; мөн
  - 2) дохионы гал хэрэгслэл; мөн
  - 3) Түргэн тусламжийн эмнэлгийн хэрэгслэлийн тухай мөн усны хангамж; мөн
  - 4) Онцгой тохиолдолын холбооны зөөврийн төхөөрөмжийн төрөл болон ажиллах долгионы давтамж.

### **125.61 Түлш**

- a) Нислэгийн маршрутын болзошгүй өөрчлөлт зэргийг тооцон төлөвлөсөн нислэгт хүрэлцэх түлшээр агаарын хөлгийг цэнэглэх тухай нислэгийн өмнөх болон нислэгийн үе дэх дахин төлөвлөлтийн түлшний бодлогыг нислэгийн АТГ эзэмшигч бүр хэрэгжүүлэх ёстой.
- b) Түлш төлөвлөлтийн бодлого нь дараахь шаардлагуудад үндэслэсэн байх ёстой:
- 1) Үйлдвэрлэгчээс гаргасан ашиглалтын заавраас авсан эсвэл түүнд агуулагдаж байгаа журам, хүснэгт, график зэрэг нь тухайн онгоцны маягийн гэрчилгээнд бичигдсэн үзүүлэлттэй нийцсэн байх; мөн
  - 2) Төлөвлөгөөт нислэг үйлдэх ашиглалтын нөхцлийг тооцохдоо:
    - i. Агаарын хөлгийн түлшний зарцуулалт хэвийн; мөн
    - ii. Жинг урьдчлан тооцсноор; мөн
    - iii. Цаг агаарын урьдчилсан байдал; мөн
    - iv. НХҮ-ийн шаардлага болон хориг; мөн
    - v. Очих аэродромын газар зүйн байрлал; мөн
    - vi. Түлшний зарцуулалтад нөлөөлөх тодорхой нөхцлүүд
- c) Энэхүү бүлгийн (d)-д зааснаас бусад тохиолдолд АТГ эзэмшигч нь тухайн нислэгт шаардагдах түлшний хэмжээг тооцохдоо дараахь хүчин зүйлсийг харгалзах ёстой:
- 1) Явгалах түлш/taxi fuel/; мөн
  - 2) Очих газар хүртэлх түлш/trip fuel/; мөн

3) Дараахь хүчин зүйлсийг тооцсон нөөц түлш/Reserve fuel/:

- i. Урьдчилан тооцоогүй ямар нэг нөхцөл үүсвэл хэрэглэх нөөц түлш /contingency fuel/
- ii. Бэлтгэл аэродром шаардлагатай бол түүнд хүрэхэд зарцуулах түлш/alternate fuel/
- iii. Ерөнхий нөөц түлш /final reserve fuel/
- iv. Тухайн төрлийн нислэгийн онцлогоос хамаарсан нэмэлт түлш

d) АТГ эзэмшигчийн Үйл ажиллагааны зааварт энэ тухай заасан бол, нислэгийн үе дэх дахин төлөвлөлтийн журмыг хангах үүднээс энэхүү бүлгийн (с)-д заасан анхаарч үзэх шаардлагатай хүчин зүйлсийг өөрөөр тооцож болно.

### 125.63 Нислэгийн хянан нягтлах тогтолцоо

a) АТГ эзэмшигч нь гэрчилгээнд нь заасан эрхийн дагуу үйл ажиллагаандаа ашиглаж байгаа агаарын хөлөг бүрээр нисэх багийн гишүүдийн нислэгийн үед мөрдөх хяналтын тогтолцоо ***Flight check system***-г бий болгох ёстой.

b) Гэрчилгээ эзэмшигч нь, энэ зүйлийн (а) -д шаардсан нислэгийн хяналтын тогтолцоог бий болгохдоо, нисэх багийн гишүүд агаарын хөлгийг удирдан жолоодоход хамааралтай шийдвэрийг аюулгүй ажиллагааг эрхэмлэн гаргах нөхцлийг хангахын тулд хүний хүчин зүйл/***human factor***/, багийн нөөцийн менежмент/***crew resource management***/ийн зарчмыг харгалзсан байх ёстой.

c) Энэ зүйлийн (а) -д шаардсан нислэгийн хяналтын тогтолцоо нь:

1) Нисэх багийн бүхээг дэх ажлыг хэрхэн аюулгүй, үр ашигтай удирдан зохион байгуулах тухай заавар, удирдамж бэлдэж өгөх; мөн

2) Нислэгийг хэрхэн аюулгүй гүйцэтгэх арга, аргачлалуудыг зааж өгөх; мөн

3) Дараахь шаардлагад нийцсэн журам, шалгах хуудасыг хэрэглэнэ:

i. Агаарын хөлгийн ашиглалтын заавар; мөн

ii. Үйлдвэрлэгчээс гаргасан техникийн ба аюулгүй ажиллагааны удирдамжууд

4) Дараахь асуудлуудыг багтаана:

i. Ашиглалтын зааварт заасан дэлгэрэнгүй шалгах хуудас/***Expanded checklist***/

ii. Нэг бүрчлэн гүйлгэн шалгах /**scan checks** /

iii. Түргэн хялбар олж хэрэглэхэд зориулсан шалгах хуудсын товъёг, түүнчлэн онцгой тохиолдолын үед хэрэглэх шалгах хуудас /**abbreviated checklists for quick reference, including emergency procedures**/

5) Хэрэв ГХХН/SEIFR-ийг зорчигч тээврийн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа бол, нислэгийн өмнөх үзлэг хийж хүн нислэгийн өмнө авах буюу салгах ёстой нэн чухал /**flight critical items**/ эд зүйлс /*Жишээ нь: уяа, хавчаар, уут г.м/-ийг тухайн үзлэгийн үед авах буюу салгах ба, гэрчилгээ эзэмшигчээс эрх олгосон өөр нэг этгээд агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын зааварт заасны дагуу дээрх нэн чухал эд зүйлсийг нислэг эхлэхээс өмнө авсан буюу салгасан гэдгийг баталгаажуулах журам зэргээс бүрдэнэ.*

d) нислэг үйлдэж нисэх багийн гишүүн бүр, энэхүү бүлгийн (а)-д заасан нислэгийн шалгах системийн шаардлагын дагуу, нисэх багийн бүхээгийн шалгах хуудсыг ашиглах ёстой:

1) Нислэгийн үе шат бүрийн өмнө болон дараа нь, түүнчлэн нислэгийн үе шатанд; мөн

2) Ердийн бус болон онцгой тохиолдолын үед.

e) 2011 оны 9 сарын 30-ны өдөр гэрчилгээ нь хүчин төгөлдөр байсан АТГ эзэмшигчдээс энэхүү бүлгийн (b) болон (c) заалтуудыг доорх нөхцөлд шаардахгүй:

1) 2012 оны 4 сарын 01-ний өдөр хүртэл эсвэл АТГ-ийн хүчин төгөлдөр хугацаа дуусах өдөр хоёрын аль түрүүлж болох өдөр хүртэл; мөн

2) Нислэгийн өмнөх үзлэг хийж хүн нислэгийн өмнө авах буюу салгах ёстой нэн чухал /**flight critical items**/ эд зүйлс /*Жишээ нь: уяа, хавчаар, уут г.м/-ийг тухайн үзлэгийн үед авах буюу салгах ба, гэрчилгээ эзэмшигчээс эрх олгосон өөр нэг этгээд дээрх нэн чухал эд зүйлсийг нислэг эхлэхээс өмнө авсан буюу салгасан гэдгийг баталгаажуулах журмыг агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын зааварт заасны дагуу мөрдөж байгаа нөхцөлд.*

## **125.65 Зорчигч – Аюулгүй ажиллагаа**

Нислэгийн үйл ажиллагаанд оролцож буй хүн бүр дараахь шаардлагыг хангах ёстой:

- 1) зорчигчдыг онгоцноос яаралтай нүүлгэн шилжүүлэх тохиолдолд, тэд нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд саад болохгүй байхаар суудал хуваарилалтыг хийнэ; мөн
- 2) Агаарын хөлөг болон түүн дотор байгаа нийт хүмүүсийн аюулгүй байдал, нислэгийн аюулгүй ажиллагааны үүднээс, согтууруулах ундаа, мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн нөлөөнд байгаа нь илт ямар ч зорчигчийг, эсвэл зүй бус байдлаар биеэ авч яваа зорчигчийг тээвэрлэхээс татгалзах эсвэл, шаардлагатай тохиолдолд агаарын хөлгөөс гаргах; мөн
- 3) Хөгжлийн бэрхшээлтэй зорчигчидод зохих ёсоор санаа тавьж таарах суудал хуваарилах мөн онцгой нөхцөл байдлын үед тусламж үзүүлэх;
- 4) Хууль сахиулагч, харгалзагчийн хяналтанд яваа зорчигчийг, бусад зорчигчдын эсвэл агаарын хөлгийн аюулгүй байдалд хохирол учруулах нөхцлийг ханган тээвэрлэх бөгөөд, тэднийг тээвэрлэх гэрээг гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны зааварт заасан журмын дагуу хийсэн байх;
- 5) Хууль сахиулагч, харгалзагчийн хяналтанд яваа зорчигч, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй зорчигч тээвэрлэх бол агаарын хөлгийн даргад энэ тухай мэдэгдсэн байна.

#### **125.67 Нисгэгчийн бүхээгт нэвтрэх**

- a) Нислэгийн үйл ажиллагаа эрхлэгч аливаа этгээд нь, тухайн нислэгт томилогдсон нисэх багийн гишүүдээс бусад ямар ч хүн, агаарын хөлгийн даргын зөвшөөрөлгүйгээр нисгэгчийн бүхээгт орох, түүн дотор аялах, эсвэл нисгэгчийн суудал эзлэх зэргийг дор зааснаас бусад тохиолдолд хориглож ёстойно:
  - 1) Багийн гишүүн; эсвэл
  - 2) ИНЕГ-ын эрх бүхий этгээд; эсвэл
  - 3) АТГ эзэмшигчийн Үйл ажиллагааны зааварт заасан журмын дагуу гэрчилгээ эзэмшигчийн зүгээс эрх олгосон этгээд.
- b) Нислэгийн үйл ажиллагаа эрхлэгч аливаа этгээд нь, нисгэгчийн бүхээгт орсон, эсвэл нисгэгчийн суудал эзэлсэн хүн бүр, АТГ эзэмшигчийн Үйл ажиллагааны зааварт заасан, аюулгүй ажиллагааны зохих журамтай танилцсан байхыг баталгаажуулах ёстой.

#### **125.69 Агаарын хөлгийн жолоо удирдлагаар оролдох**

- a) Энэхүү бүлгийн (b)-д зааснаас бусад аливаа этгээд нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй агаарын хөлгийн жолоо удирдагаар оролдох ёсгүй.
- b) АТГ эзэмшигч бүр нь, доор зааснаас бусад аливаа этгээд нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй агаарын хөлгийн жолоо удирдлагаар оролдохгүй байх талаар зохих арга хэмжээ авсан байх ёстой:
  - 1) Нисэх багийн гишүүн; эсвэл
  - 2) Дараах шаардлага хангасан ИНЕГ-ын эрх бүхий этгээд
    - i. АТГ эзэмшигч болон агаарын хөлгийн даргын зөвшөөрөлтэй
    - ii. Өөрийн ажил үүргээ гүйцэтгэж буй

### **125.71 Нислэгийн үзүүлэлт бичигчийн талаарх шаардлага**

- a) ИНД-125.367-д шаардсан бүхээгийн дуу чимээ бичигчийн хувьд, нисэх багийн аливаа гишүүн нь доорх нөхцлийг хангах ёстой:
  - 1) Хөдөлгүүрийг асаахаас өмнөх үеэс эхлэн нислэг дуусаж сүүлчийн шалгах хуудсыг уншиж дуусах хүртэл тасралтгүй ажиллана; мөн
  - 2) Хэрэв тухайн агаарын хөлөг нь, чихэвчний эсвэл маскны микрофоны тасралтгүй аудио дохиог бичих төхөөрөмжөөр тоноглогдсон бол 10 000 фут-ийн үнэмлэхүй /далайн түвшнээс дээш/ өндрөөс доош өндөрт микрофоныг тасралтгүй ашиглана; мөн
  - 3) Хэрэв хэрэв бүхээгийн дуу чимээ бичигч нь бичлэг арчих горимтой бол, сүүлийн 30 минутын бичлэгээс бусдыг зөвхөн арчих буюу арилгана.
- b) ИНД-125.369-д шаардсан нислэгийн үзүүлэлт бичигчийн хувьд, нисэх багийн аливаа гишүүн нь доорх нөхцлийг хангах ёстой:
  - 1) Агаарын хөлөг хөөрөхөөр гүйж эхлэхээс суулт үйлдэх хүртэл тасралтгүй ажиллана; мөн
  - 2) Нэг ээлжиндээ хамгийн багадаа сүүлийн 25 цагийн, агаарын хөлгийн ашиглалтын үзүүлэлтийн бүх бичлэгийг хадгалдаг байна; мөн
  - 3) Нислэгийн үзүүлэлт бичигч систем эсвэл нислэгийн үзүүлэлт бичигчийн ажиллагааг шалгах зорилгоор л нислэгийн үзүүлэлтийн зөвхөн 1 цагаас ихгүй бичлэгийг арчиж болно.
  - 4) Энэхүү бүлгийн b)-ийн 3)-д заасны дагуу арчсан бичлэгийн хувьд:

- i. Шалгалт хийх үед байсан бичлэгийн хамгийн хуучин нь байна;  
мөн
- ii. Техник үйлчилгээний зохих бичиг баримтанд бичнэ.

#### **125.72 ХҮБА/AEDRS-үйл ажиллагааны шаардлага**

АТГ эзэшигч нь, ИНД-125.377-ийн дагуу ХҮБА/AEDRS-аар тоноглохыг шаардсан агаарын хөлөг ашиглаж байгаа бол доорх шаардлагыг хангаагүй нөхцөлд ГХХН-ээр зорчигч тээвэр эрхлэхгүй:

- 1) ИНД-125.407-ийн а)-ийн 5)-д заасан журмын дагуу тухайн хөдөлгүүрийн үндсэн мэдээллийг ХҮБА/AEDRS-д суулгасан бол; мөн
- 2) Хөдөлгүүр ажиллах бүрт:
  - i. ХҮБА/AEDRS хэвийн ажиллагаатай, ямар нэг дутагдалгүй
  - ii. Хөдөлгүүр ажиллаж эхлэхээс унтраах хүртэлх ашиглалтын бүтэн цикл бүрт ХҮБА/AEDRS тасралтгүй ажиллана.

#### **125.73 Түлшээр цэнэглэх болон **соруулах /defuelling/** ажиллагаа**

а) ИНД-119-ээр олгосон АТГ-ний эрхийн дагуу нислэгийн үйл ажиллагаа эрхэлж буй аливаа этгээд нь Үйл ажиллагааныхаа зааварт заасан журмын дагуу аюулгүй ажиллагааны болон онцгой тохиолдлын үеийн нүүлгэн шилжүүлэлтийн талаарх урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан нөхцөлд, хүмүүсийг агаарын хөлөгт суулгах болон буулгах үед, 3.1C ангилалын эсвэл 3.1D ангилалын шатамхай шингэнийг агаарын хөлөгт цэнэглэх эсвэл агаарын хөлгөөс соруулж болох бөгөөд үүнд ИНД-91.15-ийн 3)-ийн заалт үл хамаарна.

б) ИНД-119-ээр олгосон АТГ-ний эрхийн дагуу нислэгийн үйл ажиллагаа эрхэлж буй аливаа этгээд нь, дараахь шаардлагыг хангасан нөхцөлд агаарын хөлгийн нэг эсвэл түүнээс олон тийрэлтэд хөдөлгүүрүүд ажиллаж байх үед, 3.1C ангилалын эсвэл 3.1D ангилалын шатамхай шингэнийг агаарын хөлөгт цэнэглэх эсвэл агаарын хөлгөөс соруулж болно:

- 1) Түлшээр цэнэглэх буюу түлш соруулж эхлэхээс өмнө, багийн аль нэг гишүүний хяналтан дор агаарын хөлгөөс бүх зорчигчдыг гарган аюулгүй зайд холдуулсан; мөн
- 2) Түлшээр цэнэглэх буюу түлш соруулах ажиллагаа бүх талаараа агаарын хөлгийн даргын хяналтан дор хийгдэж байгаа бол.



## 125.75 Нөөцөлсөн

## 125.77 Аэродром ашиглалт

а) Зөвхөн дараахь шаардлагыг хангасан тохиолдолд, нислэгийн үйл ажиллагаа эрхэлж буй АТГ эзэмшигчийн агаарын хөлөг нь тухайн аэродромд хөөрөлт буулт үйлдэх ёстой:

1) Аэродромын бодит өгөгдөхүүн байгаа, эргэн тойрны саадууд нь хязгаарлалтын хүрээнд мөн ил харааны тоноглол болон тэмдэгтүүд нь дарахь шаардлагыг хангах бол:

i. Агаарын хөлгийн ашиглалтанд заасантай нийцэж байгаа; мөн

ii. Цаг уурын минимум ашиглах бол; мөн

2) Хэрэв нислэгийн үйл ажиллагаа нь Монгол Улс болон гадаад улс хоорондын (олон улсын) шугамын тогтмол нислэг /2007 оны 07 сарын 12-оос хойш/ бол:

i. Үйл ажиллагаандаа ашиглаж буй, Монгол улсад байрлах аэродромын ХБЗ-ны үзүүр бүр нь ИНД-139-ийн Хавсралт- А.1-ийн шаардлага хангасан ХБЗ-ийн ТАЗ /төгсгөлийн аюулгүйн зурвас/-тай байна; эсвэл

ii. Хэрэв тухайн ХБЗ нь энэхүү бүлгийн а)-ийн 2)-ийн i)-д шаардсан ТАЗ-гүй бол, 2011 оны 10 сарын 12-ноос хойш нислэгийн үйл ажиллагаа явуулахдаа хөөрөх чиглэл дэх зурвасны төгсгөлийн 90м хэсгийг ТАЗ гэж тооцон, ХБЗ-ны зарласан уртаас хасаж агаарын хөлгийн хөөрөлт буултын ашиглалтын тооцоог хийнэ; мөн

iii. Үйл ажиллагаандаа ашиглаж буй, гадаад улсад байрлах аэродром бүрийн ХБЗ-ны хөөрөх чиглэл дэх зурвасны төгсгөл нь дор хаяж 150м ТАЗ-тай байх ба эсвэл түүнийг /ТАЗ-ийг/ орлох инженерийн байгууламж нь ИНЕГ хүлээн зөвшөөрөхүйц байна.

iv. Хэрэв ХБЗ нь энэхүү бүлгийн а)-ийн 2)-ийн iii)-д шаардсан ТАЗ эсвэл ТАЗ-ийг орлох инженерийн байгууламжгүй бол хөөрөх чиглэл дэх зурвасны төгсгөлийн хэсгийг ТАЗ гэж тооцон, ХБЗ-ны зарласан уртаас а)-ийн 2)-ийн iii)-д шаардсан ТАЗ-тай тэнцүү хэсгийг хасаж агаарын хөлгийн хөөрөлт буултын ашиглалтын тооцоог хийнэ.

b) хэрэв АТГ эзэмшигч нь Монгол улсын Аэронвигацийн Эмхтгэл (AIP of Mongolia)-д бүртгэгдээгүй аэродром үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бол дараахь мэдээллийг ирүүлэн бүртгүүлнэ:

- 1) Аэродромын үндсэн өгөгдөхүүн; мөн
- 2) Тухайн аэродром дээр агаарын хөлөг аюулгүй үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангасан ашиглалтын журам; мөн
- 3) Аэродромын шаардлагатай тоног төхөөрөмжүүд түүнчлэн аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмжүүдээ агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангахуйц нөхцөлд байлгах тухай журам; мөн
- 4) Аэродром ашиглалтын аливаа хязгаарлалт байгаа бол тэдгээрийг.

c) АТГ эзэмшигч нь гэрчилгээгээр олгогдсон эрхийнхээ дагуу ашиглаж буй, хөөрөлтийн хамгийн их жин нь 5700 кг буюу түүнээс бага агаарын хөлөг өдрийн цагаар, ИХНД-ээр, хөөргөх буулгах зорилгоор ашиглаж байгаа бүх газар дараахь шаардлага хангасан байна:

1) ХБЗ нь:

- i. Өргөн нь, агаарын хөлгийн гадна талын үндсэн дугуй хоорондын зайнаас дор хаяж 2 дахин өргөн; мөн
- ii. Гадаргуу нь ямарваа нэг овон товонгүй, мөн урт нь ашиглах агаарын хөлөг хөөрч буухад хангалттай; мөн

2) ХБЗ-ийн эргэн тойрондох аюулгүй зурвас хэсгийн өргөн нь наад зах нь агаарын хөлгийн далавчны дэлгэмэл урт (далавчны үзүүр хоорондын зай)-аас 2,5 дахин өргөн эсвэл 30м байх бөгөөд аль ихийг нь авна.

d) Энэхүү бүлгийн c)-ийн дагуу үйл ажиллагаа явуулаагүй нөхцөлд, дараахь шаардлагыг хангаагүй газарт өөрийн эзэмшлийн нэг ч агаарын хөлөг хөөрөлт буулт үйлдэхгүй байх нөхцлийг АТГ эзэмшигч бүрдүүлэх ёстой:

- 1) Ашиглаж буй агаарын хөлөгтөө тохирох аэродромын кодыг Хавсралт В-ийн Хүснэгт-1-ээр тодорхойлсон
- 2) Аэродромын өргөн нь, ашиглаж буй агаарын хөлөгтөө тохирох кодоор Хавсралт В-ийн Хүснэгт-2-оор тодорхойлсон аэродромын өргөнтэй тохирч байна.

- 3) ИНД-139-ийн Хавсралт В-ийн Хүснэгт В-1-д заасан өгөгдөхүүнээр, ашиглах ХБЗ-ийн эргэн тойрондох аюулгүйн зурвасны байж болох хамгийн бага өргөнийг тодорхойлсон.
- е) АТГ эзэмшигч нь, энэхүү бүлгийн с) болон d)-ийн шаардлагыг үл харгалзан, с) болон d)-д зааснаас нарийн ХБЗ-г ашиглаж болох багаад хэрэв агаарын хөлөг нь:
- 1) Илүү нарийн зурвасан дээр хөөрч буух туршилт хийгдэж гэрчилгээжсэн гэж агаарын хөлгийн ашиглалтын зааварт заасан бол; эсвэл
  - 2) Илүү нарийн зурвас нь ИНЕГ-аас хүлээн зөвшөөрч болохуйц бол; эсвэл
  - 3) a lesser minimum runway width was prescribed for the aeroplane in an air service certificate, issued to the holder of the air operator certificate under regulation 136 of the Civil Aviation Regulations 1953 before 6 January 1993.

#### **125.79 ГХХН –Зорчигч тээвэр**

- а) ГХХН –ээр Зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхэлж байгаа АТГ эзэмшигч аливаа аливаа этгээд нь дараахь шаардлагыг хангах ёстой:
- 1) Ашиглах аэродром бүрээр маршрутын гарын авлагыг агаарын хөлгийн даргын хэрэглээнд бэлдэж өгөх ба түүнд хэрэглэлээр буултын оролт болон хөөрөлт үйлдэж байхад хөдөлгүүр татгалзах зэрэг онцгой тохиолдолд эргэн тойрны саадын өндрүүдийг мэдэж байх түүнчлэн мөн:
    - i. ХБЗ-д хүрэх бусад боломжит замууд; мөн
    - ii. ХБЗ-д буухад хэрэглэх глиссад болон өндрийн минимум; мөн
  - 2) ГХХН-т учирч болох аливаа хүндрэлтэй асуудлуудыг эртнээс тодруулах болон урьдчилан сэргийлэх зорилго бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлэх бөгөөд түүнд:
    - i. ГХХН-ийн зорчигч тээврийн аюулгүй ажиллагаанд эрсдэл учруулж болзошгүй аливаа тохиолдлыг бүртгэх; мөн
    - ii. боломжит бэлтгэл аэродромын цаг агаар нь төлөвлөлтийн хязгаарлалтаас доош байснаас болж ГХХН-ийн зорчигч тээврийн үйл ажиллагаа хойшилсон тохиолдлын бүртгэл; мөн
    - iii. Агаарын хөлөг, түүний системийн найдвартай байдлыг үнэлэх зорилготой техник үйлчилгээний мэдээллийн санг агаарын хөлөг бүрээр гаргана; мөн

- iv. Хөдөлгүүр үйлдвэрлэгчийн өргөтгөсөн техник үйлчилгээний хөтөлбөрийн хэрэгжилт, мөн
- 3) Энэ зүйлийн (2)-ийн (III) -т шаардсан мэдээллийн сан нь дараахь мэдээллийг агуулсан байна:
- i. ГХХН-ийн зорчигч тээврийн нислэгийн тоог, сар бүрээр; мөн
  - ii. ГХХН-ийн зорчигч тээврийн нислэг нь очих газартаа хүрч чадалгүй буцсан, бэлтгэл аэродромд буусан зэрэг төлөвлөгөө өөрчлөгдсөн (diversion) тохиолдолуудын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл; мөн
  - iii. Агаарын хөлгийн дутагдлаас болж төлөвлөсөн ГХХН-ийн зорчигч тээврийн нислэг цуцлагдсан тохиолдлуудын бүртгэл; мөн
- 4) Энэхүү зүйлийн (2), (3)-д шаардсан мэдээллийг чанарын баталгаажуулалтын хөтөлбөрийн дагуу хуанлийн сар бүр авч хэлэлцэх ба ямар нэгэн засч залруулах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан бол тэр тухай бүртгэсэн байх; мөн
- 5) Энэхүү зүйлийн (2), (3)-т шаардсан мэдээлэл болон энэ зүйлийн (4)-т заасан бүртгэлийг хуанлийн сар бүр ИНЕГ-т зургаан сарын турш ирүүлэх ба, үүний дараа хуанлийн 3 сар тутамд нэг удаа дээрх мэдээллийг ирүүлж байх зөвшөөрлийг энэ зүйлийн (b)-д заасаны дагуу ИНЕГ олгож болно; мөн
- 6) Энэ дүрмийн Бүлэг-9-д шаардсан сургалтын хөтөлбөр бүрт дараахь сургалтууд багтсан байна:
- i. Олон хөдөлгүүртэй агаарын хөлөг дээр хуримтлуулсан ХНД-ийн нислэгийн аливаа дадлага туршлагыг бататган хөгжүүлэх мөн ганц хөдөлгүүрт агаарын хөлөг дээр хуримтлуулсан ИХНД-ийн нислэгийн аливаа дадлага туршлагыг бататган хөгжүүлж ГХХН-ийн зорчигч тээвэрлэх нислэгт шилжүүлэх; мөн
  - ii. ГХХН-ийн зорчигч тээвэрлэх нислэгийн үе дэх ажиллагаа шаардлагатай бол мөстөлтөөс хэрхэн зайлсхийх тухай; мөн
  - iii. Нислэгийн үйл ажиллагааг шөнөөр үйлдэх бол ГХХН-ийн зорчигч тээврийн шөнийн сургалт; мөн
  - iv. Дохиолол ажилласан болон ямар нэг зүйл хэвийн бус байгаа үед авах арга хэмжээ болон ажиллагааны талаарх сургалт зэрэг багтна.

b) Нислэгийн аюулгүй үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзсэн тохиолдолд энэ зүйлийн а)-ийн 5)-д заасны дагуу холбогдох мэдээлэл болон бүртгэлийг ирүүлэх хугацааг сунгаж болно.

### **125.81 Гагц хөдөлгүүртэй агаарын хөлгийн үйл ажиллагаа – ХНД**

Коммерийн нислэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аливаа этгээд нь ганц хөдөлгүүртэй агаарын хөлгөөр ХНД-ээр зорчигч тээвэрлэх ёсгүй.

### **125.83 Үйл ажиллагааг хязгаарлах эсвэл түтгэлээх түдгэлзүүлэх**

АТГ эзэмшигч аливаа этгээд нь нислэгийн аюулгүй ажиллагаанд хохирол учрахаар нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн аюул заналыг арилгах хүртэл үйл ажиллагааг түр зогсоох, түтгэлзэх, үйл ажиллагааг хязгаарлах зэрэг шаардлагатай арга хэмжээг авах ёстой.

### **125.85 ИХНД-ийн өндрийн минимум**

ИНД-91.311-ийн с) заалт нь энэхүү дүрмийн дагуу нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн даргад үл хамаарна.

### **125.87 Усан дээгүүрх нислэг**

а) АТГ эзэмшигч нь гэрчилгээгээр олгогдсон эрхийн дагуу үйл ажиллагаандаа ашиглаж буй агаарын хөлгүүд нь дараахь шаардлагыг хангаагүй бол үргэлжилсэн их усан дээгүүрх нисэхгүй байх нөхцлийг хангах үүрэгтэй:

- 1) ХНД-ийн нислэг; мөн
- 2) Багийн гишүүд нь тухайн агаарын хөлгийн усан дээрх онцгой тохиолдлын буултын дараа нүүлгэн шилжүүлэлт хийх журмын зохих сургалтанд хамрагдсан; мөн
- 3) Усан дээрх онцгой тохиолдлын буултын дараа нүүлгэн шилжүүлэлт хийх тохиолдолд, агаарын хөлөгт байгаа хүмүүсийн аврагдах боломжид нөлөөлөх болзошгүй эрсдлийг тодорхойлохын тулд үйл ажиллагааны орчин, уур амьсгалын нөхцөл зэргийг тооцон, эрсдлийн үнэлгээ гаргасан байна.

### **b) Нөөцөлсөн**

### **125.89 Шөнийн ниислэгийн үйл ажиллагаа**

а) Шөнийн цагаар нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга нь ХНД-ээр нисэх үүрэгтэй.

b) Хэрвээ дараахь шаардлагыг хангаж байгаа бол агаарын хөлгийн дарга нь шөнийн цагаар ИХНД-ийн нислэг үйлдэж болно:

- 1) АТГ эзэмшигч нь шөнийн ИХНД-ийн нислэгийн тогтсон журамтай бол; мөн
- 2) АТГ-ний Хавсралт- Үйл ажиллагааны тодорхойлолтонд нь шөнийн цагаар ИХНД-ээр нислэг үйлдэх эрхийг тусгасан бол; мөн
- 3) Тухайн нисэн гарсан аэродромдоо эргэн бууснаар нислэг дуусгавар болж байгаа бол; мөн
- 4) Тухайн нислэг нь:
  - i. Аэродром орчмын 45км /25NM/-ийн радиус дотор; мөн
  - ii. Газрын гадарга/AGL/-аас дээш 3000фут-ээс их өндөрт; мөн
- 5) Цаг агаарын нөхцөл байдлын хувьд, үүлний доод суурийн өндөр газрын гадаргаас дээш 3000 фут-ээс их, хараа 16км-ээс их;
- 6) Агаарын хөлгийн дарга нь хүчин төгөлдөр Агаарын Тээврийн Нисгэгчийн Үнэмлэх /ATPL/-тэй; мөн
- 7) Нисэх багийн гишүүн бүр нь хүчин төгөлдөр ХНД-ийн эрхтэй; мөн
- 8) Агаарын хөлөг нь ИНД-91.511 болон ИНД-91.519-ийн шаардлагын дагуу тоноглогдсон; мөн
- 9) Нислэгийн үйл ажиллагааг энэхүү бүлгийн 1)-д шаардсан журмын дагуу гүйцэтгэж байгаа бол.

#### **125.91 Онцгой тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө**

a) АТГ эзэмшигч аливаа этгээд нь, агаарт эсвэл газарт онцгой тохиолдол үүссэн нөхцөлд зохицуулах мөн ямар нэг хүн гэмтэж бэртэх эрсдлийг бууруулах зорилго бүхий авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан байх ёстой.

b) АТГ эзэмшигчийн Онцгой тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө нь дараахь мэдээлэлд үндэслэх боловч зөвхөн түүгээр хязгаарлагдах ёсгүй:

- 1) Нислэгийн үйл ажиллагаа явуулж буй агаарын замын төрөл болон урт; мөн
- 2) Аэродром дээрх газрын тоног төхөөрөмжүүд; мөн
- 3) Орон нутгын онцгой байдлын тусламж үйлчилгээ; мөн
- 4) Нислэгийн Хөдөлгөөний Үйлчилгээ /АТС/-ний тоног төхөөрөмж; мөн

- 5) Онцгой тохиолдолд өртсөн байж болзошгүй байгаа агаарын хөлгийн маяг, хүн болон суудлын тоо мөн төлбөрт ачаалалтын хэмжээ зэрэг мэдээлэл.
- с) Агаарт онцгой тохиолдол үүссэн нөхцөлд АТГ эзэмшигчийн авах арга хэмжээний төлөвлөгөөнд дараахь асуудлуудыг тусгасан байна:
- 1) Нислэгийн үед агаарын хөлөгт онцгой нөхцөл байдал үүссэн тухай удирдах ажилтан мэдсэн тохиолдолд тэдгээр ажилтнуудын нэн даруй шийдвэр гаргах, арга хэмжээ авах, мөрдөх журманд дараахь асуудлуудыг тусгасан байх шаардлагатай:
    - i. Онцгой нөхцөл байдал үүссэн тухай агаарын хөлгийн даргын мэдээг авна; мөн
    - ii. Агаарын хөлгийн даргын шийдвэрийг лавлана; мөн
    - iii. Тухайн шийдвэрийг бүртгэж авна; мөн
  - 2) Хэрэв энэ бүлгийн с)-ийн 1)-д дурьдсан холбоог, удирдах бүрэлдэхүүн агаарын хөлгийн даргатай барих боломжгүй тохиолдолд дараахь асуудлуудыг тусгасан журмыг мөрднө:
    - i. Онцгой байдал зарлана; мөн
    - ii. Нөхцөл байдалд тохируулан шаардлагатай арга хэмжээг авна.
  - 3) АТГ эзэмшигч нь, бүх ажилтан албан хаагчдаа холбогдох сургалтанд хамруулан, онцгой тохиолдолд хэрхэн ажиллах, ямар үүрэг хариуцлага хүлээх талаар зохих мэдлэг чадвар эзэмшүүлсэн байх ёстой.

### **125.93 ГХХН – Хөдөлгүүрийн үзүүлэлт эсвэл AEDRS**

#### **хэвийн бус үед авах арга хэмжээ**

- а) ИНД-125.377-ийн заалтын дагуу AEDRS-ээр тоноглохыг шаардсан агаарын хөлөг ашиглаж байгаа бол дараахь зүйлсийг нягтлан шалгаагүй тохиолдолд, ГХХН-ийн зорчигч тээвэрлэхээр хөөрөлт үйлдэж болохгүй:
- 1) AEDRS татгалзсан эсэх; эсвэл
  - 2) Хөдөлгүүрийн үзүүлэлт хязгаараас давсан тухай AEDRS мэдээлж байгаа эсэх; эсвэл
  - 3) Хөдөлгүүрийн үзүүлэлтүүд хэвийн байгаа эсэх.

- b) Нислэгийн үед хөдөлгүүрийн үзүүлэлтүүд хэвийн бус байдал үүссэн нөхцөлд, ГХХН-ийн зорчигч тээврийн нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга нь дараахь арга хэмжээг авах үүрэгтэй:
- 1) Үүссэн нөхцөл байдлын талаар холбогдох НХҮ-ний нэгжид нэн даруй мэдээлэх; мөн
  - 2) Хамгийн ойрын аюулгүй буулт үйлдэж болох боломжит аэродром руу цаг алдалгүй нисэх
- c) ГХХН-ийн зорчигч тээврийн нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга нь, зөвхөн нислэгт төдийгүй хөлгийн бүхээгт байх бүхий л хугацаанд ажиглагдсан, AEDRS-ийн дутагдлын талаар өдөр, цаг хугацааны хамт, хөлгийн техник үйлчилгээний дэвтэрт цаг алдалгүй тэмдэглэх үүрэгтэй.

### **125.95 ГХХН – Бүсийн навигацийн тоноглолын системийн талаарх шаардлага**

АТГ эзэмшигчийн, ГХХН-ийн зорчигч тээвэрт ашиглаж байгаа бүх агаарын хөлөг нь, ИНД-125.361-ийн d)-ийн 3)-д заасан бүсийн навигацийн тоноглолын системтэй байх ба тэр нь:

- 1) Гэрчилгээ эзэмшигчийн батлагдсан маршрутын гарын авлагад орсон, маршрутын дагуух ашиглах боломжтой бүх аэродромуудын мэдээллийг оруулан программчилсан байна; мөн
- 2) ГХХН-ийн зорчигч тээврийн нислэг бүртээ, тухайн навигацийн системийг үйлдвэрлэгчээс зөвлөсөн, хүчин төгөлдөр навигацийн мэдээллийн санг ашиглана.

## **БҮЛЭГ 3 – АШИГЛАЛТЫН ХЯЗГААРЛАЛТУУД БОЛОН ЦАГ УУРЫН ШААРДЛАГА**

### **125.151 Зорилго**

Энэ бүлэгт ИХНД болон ХНД-ийн шаардлагууд мөн холбогдох цаг уурын шаардлагууд багтсан болно.

### **125.153 Цаг уурын мэдээ**

- a) Нислэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аливаа этгээд нь, нислэгийн үйл ажиллагаанд зориулсан, цаг уурын мэдээ гаргадаг дараахь байгууллагуудын мэдээг үндэслэн нислэг төлөвлөлт, гүйцэтгэл мөн хяналтыг явуулах үүрэгтэй:
- 1) Энэ зүйлийн (b)-д заасанчлан, Монгол Улсын нутаг дэвсгэр дотор үйлдэх нислэгийн хувьд, ИНД-174-ийн дагуу олгосон нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч; эсвэл



2) Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна үйлдэх нислэгийн хувьд, нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь:

i. ИНД-174-ийн шаардлагатай дүйцэх стандартыг хангасан; мөн

ii. ИКАО-ийн гишүүн аль нэг орноос нисэхийн цаг уурын үйлчилгээний эрх авсан байна.

b) Хэрэв АТГ эзэмшигчийн зүгээс, ИНД-174.6-ийн шаардлагын дагуу гаргасан цаг уурын ерөнхий мэдээг хэрэгцээ хангана гэж үзсэн бол, тухайн гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээний хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэр дотор эхэлж дотор дуусах нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга нь дээрх цаг уурын ерөнхий мэдээг үндэслэн ХНД-ээр буултын оролтыг үйлдэж болно.

### **125.155 Цаг агаарын нөхцөл – ИХНД-ийн нислэг**

a) Маршрутын дагуух мэдээ эсвэл бодит болон урьдчилсан мэдээг хослуулан дүгнэхэд, нийт маршрутын дагуу эсвэл ИХНД-ээр нисэх шаардлагатай маршрутын хэсэгт ИНД-91 болон зүйлийн b)-д заасан ИХНД-ийн минимумыг хангахгүй байгаа бол ИХНД-ийн нислэгийг агаарын хөлгийн дарга эхлэхгүй байх үүрэгтэй.

b) Хяналттай агаарын зайн гадна ИХНД-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга нь дараахь үүрэгтэй:

1) Үүлний доод суурийн өндөр газрын гадаргаас дээш 1000 фут /300м/-ээс их, нислэг дэх алсын барааны харагдац 5км-ээс их цаг агаарын нөхцөлд нислэг үйлднэ; мөн

2) Үүлний доогуур, үүлэнд оролгүйгээр, үргэлж газар харагдах нөхцөлд ниснэ; мөн

3) Энэ зүйлийн c)-д зааснаас бусад тохиолдолд scattered буюу 1/8-4/8-ээс их октанттай үүлэн дээгүүр нисэхгүй.

c) Агаарын хөлөг нь дараахь шаардлагыг хангаагүй бол ИХНД-ээр нисч байгаа агаарын хөлгийн дарга нь scattered буюу 1/8-4/8-ээс их октанттай үүлэн дээгүүр нисэхгүй байх үүрэгтэй:

1) ХНД-ийн шаардлага хангасан, тухайн агаарын хөлгөөр ХНД-ийн нислэг гүйцэтгэхэд байх ёстой шаардлагатай тооны нисэх багийн гишүүн байгаа, хүчин төгөлдөр ХНД-ийн зэрэглэлтэй, тэр нь бүртгэлтэй бол; мөн

- 2) ХНД-ийн нислэгт шаардлагатай радио навигацийн тоног төхөөрөмжүүдийг оролцуулан, ХНД-ийн нислэгт шаардлагатай бүх тоног төхөөрөмжүүд нь бүрэн бүтэн, хэвийн ажиллагаатай; мөн
- 3) Нэг хөдөлгүүр нь татгалзсан нөхцөлд үүлнээс дээш 1000фут /300м/-ын зайтай өнгөрөх эерэг налуу бүхий хийсвэр траектороор нисэх чадвартай; мөн
- 4) ХНД-ээр буултын оролт үйлдэн сууж болзошгүй аэродром руу навигаци хийн очиход хэрэглэгдэх радио навигацийн тоног төхөөрөмжийг суурилуулна; мөн
- 5) ХНД-ээр буултын оролт үйлдэн сууж болзошгүй аэродром руу ХНД-ээр нисэн очиход хүрэлцэх хангалттай хэмжээний аялалын болон нөөц түлштэй байна.

### **125.157 Цаг агаарын нөхцөл – ХНД-ийн нислэг**

- а) Маршрутын дагуух мэдээ эсвэл бодит болон урьдчилсан мэдээг хослуулан дүгнэхэд, доор заасан нөхцлийг хангахгүй бол ХНД-ийн нислэгийг агаарын хөлгийн дарга эхлэхгүй байх үүрэгтэй:
  - 1) Нисэн очих тооцоот цагаар очих аэродром дээрх цаг агаарын нөхцөл нь, холбогдох AIP-д заасан тухайн аэродромын ХНД-ийн минимумд эсвэл түүнээс сайн байна; эсвэл
  - 2) Хэрэв зөвхөн нэг бэлтгэл аэродром нислэгийн төлөвлөгөөнд тусгагдсан бол үүлний доод суурийн өндөр болон алсын барааны харагдац нь ИНД-91.405-ийн а)-ийн 2)-ийн шаардлагад нийцсэн байна; эсвэл
  - 3) Хэрэв 2 эсвэл түүнээс олон бэлтгэл аэродром нислэгийн төлөвлөгөөнд тусгагдсан бол нисэн очих тооцоот цагаар бэлтгэл аэродромууд дээрх цаг агаарын нөхцөл нь үүлний доод суурийн өндөр болон алсын барааны харагдацын хувьд ИНД-91.405-ийн б)-ийн шаардлагад нийцсэн байна;
- б) нислэгийн төлөвлөгөөнд тусгасан бэлтгэл аэродромуудын ядаж 1 нь ч нисэн очих тооцоот цагаар үүлний доод суурийн өндөр болон алсын барааны харагдацын хувьд ИНД-91.405-ийн б)-ийн шаардлагыг хангахгүй байгаа бол агаарын хөлгийн дарга нь ХНД-ийн нислэгийг эхлэхгүй байх үүрэгтэй ба хэрэв:
  - 1) Нисэх гарах эсвэл нисэх очих аэродром нь Монгол улсын нислэгийн мэдээллийн бүс (FIR)-ээс гадна бол; мөн
  - 2) Ашиглаж буй агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын зааварт заасан шаардлагыг хангах салангид 2 тусдаа ХБЗ нисэх очих аэродромд нь байхгүй бол.

### **125.159 Аэродромын минимум – ХНД-ийн нислэг**

- а) Хэрэв хэрэглэлийн буултын оролтын сүүлийн шат */final approach segment/*-ыг эхлүүлэхээс өмнө буюу буултын оролтын цэгийг өнгөрөхөөс өмнө бодит цаг агаарын мэдээгээр аэродромын алсын барааны харагдац, ойртолтондоо ашиглаж байгаа холбогдох AIP-д хэвлэгдсэн хэрэглэлийн алсын барааны харагдацаас бага бол агаарын хөлгийн дарга нь хэрэглэлийн буултын оролтыг, оролтын хяналтын цэг */final approach fix/* рүү түүнийг өнгөрөхөөр үргэлжлүүлэхгүй, эсвэл буултын оролтын хяналтын цэг */final approach fix/* ашиглаагүй бол хэрэглэлийн буултын оролтын сүүлийн шатыг эхлүүлэхгүй.
- б) Энэ бүлгийн а)-д нийцүүлэх үүднээс буултын оролтын сүүлийн шатыг дараахь нөхцөлд эхэлсэнд тооцно:
- 1) оролтын хяналтын цэг */final approach fix/*-ээс эсвэл хэрэглэлийн оролтын журманд заасан тоног төхөрөмжөөс; эсвэл
  - 2) хэрэглэлийн оролтын журманд оролтын хяналтын цэг */final approach fix/*-ийг тогтоогоогүй бол мөн процедурын эргэлт */procedure turn/* хийхийг журманд заасан бол процедурын эргэлт */procedure turn/* хийж дуусан хэрэглэлийн оролтын журманд заасан зайд буултын курс дээр агаарын хөлөг гарч ирэх.

### **125.161 ХНД-ээр нисэн гарах хязгаарлалт**

Агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа аливаа этгээд нь, , цаг агаарын нөхцөл ИНД-91.413-д заасан хөөрөлтийн минимум-д эсвэл түүнээс сайн байгаа хэдий ч мөнхүү ИНД-91.413-д заасан ХНД-ийн буултын минимумаас муу бол, ашиглаж буй агаарын хөлөг нь олон хөдөлгүүртэй биш бол, мөн дараахь шаардлагыг хангасан зохих аэродромгүй аваас ХНД-ийн нислэгийг эхлэх ёсгүй:

- 1) 2 хөдөлгүүртэй агаарын хөлгийн хувьд, нэг хөдөлгүүр нь татгалзсан үеийн маршрутын хурдаар, салхийг тооцолгүйгээр, хөөрсөн аэродромоосоо 1 цаг нисэн хүрэх зайтай; эсвэл
- 2) 3 болон түүнээс олон хөдөлгүүртэй агаарын хөлгийн хувьд, нэг хөдөлгүүр нь татгалзсан үеийн маршрутын хурдаар, салхийг тооцолгүйгээр, хөөрсөн аэродромоосоо 1 цаг нисэн хүрэх зайтай.

### **125.163 Хөөрөлтийн багасгасан минимум**

- а) Хэрэв АТГ эзэмшигч нь өөрийн Үйл ажиллагааны зааварт заасан Хөөрөлтийн багасгасан минимумын журмыг мөрдөж ажиллах нөхцлийг бүрдүүлсэн

тохиолдолд ИНД-91.413-ийн г)-д заасан хөөрөлтийн минимумаас бага минимумаар, олон хөдөлгүүртэй агаарын хөлгөөр хөөрөлт үйлдэж болно.

b) Багасгасан минимумаар хөөрөх журманд дараах асуудлуудыг тусгасан байна:

- 1) Нисэх багийн гишүүн бүр нь багасан минимумаар хөөрөх эрхтэй; мөн
- 2) Ашиглах ХБЗ нь төвийн шугамын тэмдэглэгээтэй эсвэл төвийн шугамын гэрэлтэй; мөн
- 3) Багасгасан минимумаар хөөрөх ХБЗ нь холбогдох AIP-д бүртгэлтэй; мөн
- 4) Хэрэв агаарын хөлөг нь хоёр хөдөлгүүрт сэнсэт агаарын хөлөг бол, бүрэн ажиллагаатай автомат флюгерийн систем эсвэл **сэнсний автомат удирдлагатай**; мөн
- 5) Алсын барааны харагдацыг RVR-аар тогтоосон; мөн
- 6) Хөөрөлтийн шаардлага хангахуйц алсын барааны харагдац байгаа эсэхийг тогтоох, ажиглалт хийх арга нь ИНЕГ-аас хүлээн зөвшөөрөхүйц байна.

#### **125.165 ХНД-ийн журмууд**

a) Дор дурьдсанаас бусад тохиолдолд ХНД-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга нь холбогдох AIP-д бүртгэлтэй агаарын замаар нислэг үйлдэх үүрэгтэй:

- 1) Илэрхий аюултай нөхцөл байдлаас зайлсхийх шаардлагатай; эсвэл
- 2) НХҮ-ийн радарын хяналтан дор нислэг үйлдэж байвал; эсвэл
- 3) НХҮ-ийн заавраар агаарын замтай паралель /off-set; off-route/ нисч байвал; эсвэл
- 4) АТГ-ээр тийм эрх олгон үйл ажиллагааны зааварт нь ингэхийг зөвшөөрсөн бол.

b) Зохих НХҮ-ний нэгжээс холбогдох зөвшөөрөл олгоогүй тохиолдолд, тухайн аэродромын холбогдох AIP-д заасан ХНД-ийн оролтын болон хөөрөлтийн ямарваа журмыг, агаарын хөлгийн дарга, хяналттай агаарын зайд заавал мөрдөх үүрэгтэй.

c) Хяналттай агаарын зайд, холбогдох AIP-д заасан ХНД-ийн оролтын болон хөөрөлтийн ямарваа журмыг агаарын хөлгийн дарга заавал мөрдөх үүрэгтэй.

- d) АТГ эзэмшигч нь, ашиглаж буй агаарын хөлөг нь чиг шулуун нислэгийн жирийн хурдаар, салхийг тооцолгүйгээр 45 минут нисэн шаардлага хангасан аэродром хүрэх зайнаас хол зайд ГХХН-ийн зорчигч тээврийн үйл ажиллагааг явуулахгүй байх үүрэгтэй.
- e) Энэ зүйлийн d)-ийн хүрээнд, шаардлага хангасан гэж дараахь аэродромыг хэлнэ:
- 1) Хэрэв аэродромыг бэлтгэл аэродромоор сонгосон бол, ашиглаж болзошгүй цагаар тухайн аэродромын цаг агаар нь батлагдсан минимумд эсвэл түүнээс сайн бол; мөн
  - 2) Ашиглаж буй агаарын хөлөгт тохирох тоног төхөөрөмж, зохих үйлчилгээ байх ба тэдгээрийн тоонд:
    - i. Цаг уурын мэдээний үйлчилгээ; мөн
    - ii. Холбогдох AIP-д ХНД-ээр буултын оролтын ядаж нэг журам байвал.

## **БҮЛЭГ 4 – АШИГЛАЛТ**

### **125.201 Зорилго**

- a) Энэ бүлгийн b); c) болон d)-д заасныг үл тооцон энэхүү бүлэг нь бүхэлдээ нислэгийн үйл ажиллагаанд ашиглах агаарын хөлгийн ашиглалтын хязгаарлалтуудыг багтаасан болно.
- b) ИНД-125.229-өөс ИНД-125.235-ийг оруулан, хоорондох дүрмийн шаардлагыг, дараахь гэрчилгээтэй сэнст хөдөлгүүрт агаарын хөлөгт хамаарахгүй:
- 1) FAR-23-ийн жирийн ангилал эсвэл нислэгт тэнцэх чадварын түүнтэй дүйцэх стандарт; эсвэл
  - 2) SFAR-23-ийн нислэгт тэнцэх чадварын стандарт эсвэл түүнтэй дүйцэх стандарт.
- c) Энэ бүлгийн шаардлагыг бүрэн хангах боломжгүй агаарын хөлгийн хувьд ашиглалтын тусгай хязгаарлалтын дагуу үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгож болно.

### **125.203 Нөөцөлсөн**

### **125.205 ИНД-125-ийн Бүлэг Г – ийн шаардлага хангасан байдал**

FAR-25-ийн нислэгт тэнцэх чадварын стандарт эсвэл түүнтэй дүйцэх стандартаар гэрчилгээжсэн агаарын хөлгүүд нь, ИНД-121-ийн Бүлэг Г-д заасан нислэгийн ашиглалтын хязгаарлалтын хүрээнд үйл ажиллагаа явуулах нөхцлийг АТГ эзэмшигч бүр хангах ёстой.

### **125.207 Агаарын хөлгийн ерөнхий ашиглалт**

АТГ эзэмшигч нь агаарын хөлөг бүрийнхээ хувьд дараахь нөхцлийг хангах ёстой:

- 1) Нислэг үргэлжлэх хэмжээгээр цаашид буурна гэж тооцсон хөөрөлтийн жин нь яг хөөрөлтийг эхлэх үед энэхүү бүлэгт заасан жингээс их байж болохгүй; мөн
- 2) Энэхүү бүлэгт заасан ашиглалтын шаардлагыг хангах эсэхийг тодорхойлоход хэрэглэж байгаа ашиглалтын өгөгдөхүүнүүд нь:
  - i. Агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын зааварт орсон; эсвэл
  - ii. Бохирдолттой зурвасандах буултын дистанцийн өгөгдөхүүний хувьд, агаарын хөлөг үйлдвэрлэгчээс хангасан бөгөөд ИНЕГ-ийн зүгээс хүлээн зөвшөөрөхүйц байна.

### **125.209 Хөөрөлтийн дистанц**

a) АТГ эзэмшигч нь агаарын хөлөг бүрийнхээ хувьд дараахь нөхцлийг хангах ёстой:

- 1) Хөөрөлтийн жин нь нислэгийн ашиглалтын зааварт заасан хөөрөлтийн хамгийн их жингээс хэтрээгүй байх; мөн
- 2) Хөөрөлтийн шаардлагатай дистанц нь хөөрөлтийн гүйлтийн боломжит уртын 85%-аас хэтрэхгүй байх.

b) энэхүү бүлгийн a)-ийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах тооцоондоо дараахь зүйлсийг тооцох ёстой:

- 1) Хөөрөлтийн гүйлтийн боломжит урт; мөн
- 2) Хөөрөхөөр гүйж эхлэх үе дэх агаарын хөлгийн жин; мөн
- 3) Аэродромын даралтын өндөр; мөн
- 4) Аэродром дээрх гаднах агаарын хэм /температур/; мөн
- 5) ХБЗ-ны гадаргуугын төрөл болон нөхцөл байдал; мөн
- 6) Хөөрөлтийн чиглэл дэх ХБЗ-ийн налуу; мөн

- 7) Мэдээгээр өгсөн өөдөөс үлээх салхины 50%-аас ихгүй хэсгийг эсвэл мэдээгээр өгсөн арын салхины 150%-аас багагүй хэсгийг.

### 125.211 ХБЗ-ийн гадаргуу болон зурвасны налуугын нөлөөг тооцох

АТГ эзэмшигч нь, хэрэв бэлтгэл аэродромын ашиглалтын өгөгдөрүүн байхгүй бол, ИНД-125.209(b)(5) эсвэл ИНД-125.229(c)(4) -ийн дагуу, ХБЗ-ны гадаргууг харгалзан тооцсон хөөрөлтийн дистанц болон ИНД-125.223(c)(3) болон ИНД-125.233(c)(3)-ийн дагуу тооцсон буултын дистанц нь дараахь шаардлагыг хангах нөхцлийг бүрдүүлнэ:

- 1) Өөр төрлийн гадаргуутай ХБЗ-д хэрэглэхдээ Хүснэгт-1-д заасан өгөгдөхүүнийг ашиглана; мөн
- 2) Дараахь өгөгдөхүүнийг ашиглан зурвасны налууг тооцно:
  - i. Хамгийн дээд тал нь өгсүүр налуу 3% байх ба 1%-ийн өгсүүр бүрт, хөөрөлтийн дистанцийг 5%-аар нэмж тооцно; эсвэл
  - ii. Хамгийн дээд тал нь өгсүүр налуу 3% байх ба 1%-ийн өгсүүр бүрт, буултын дистанцийг 5%-аар хорогдуулж тооцно ; эсвэл
  - iii. Хамгийн дээд тал нь уруу налуу 3% байх ба 1%-ийн уруу бүрт, хөөрөлтийн дистанцийг 5%-аар хорогдуулж тооцно ; эсвэл
  - iv. Хамгийн дээд тал нь уруу налуу 3% байх ба 1%-ийн уруу бүрт, буултын дистанцийг 5%-аар нэмж тооцно.

### ХҮСНЭГТ-1

Гадаргуугын төрөл	Хөөрөлтийн дистанцид үйлчлэх нөлөө	Зогсох хурдатгалын дистанцид үйлчлэх нөлөө	Буултын дистанцид үйлчлэх нөлөө
Paved- (асфальт, цемент зэрэг хучилттай)	x1,00	x1,00	x1,00
Soal- (шүрэн хад маягийн нийлмэл бүтэц)	x1,00	x1,03	x1,05
Металл	x1,05	x1,06	x1,08
Дагтаршуулсан шороон хөрс	x1,08	x1,14	x1,16

Зүлэг	х1,14	х1,20	х1,18
-------	-------	-------	-------

### 125.213 Хөөрөлтийн хийсвэр траектор- ХНД-ийн агаарын хөлөг

- а) Агаарын тээвэрлэгчийн Гэрчилгээ эзэмшигч нь ХНД-ээр нисч байгаа агаарын хөлөг нь, хэрэв хоёр буюу түүнээс дээш хөдөлгүүртэй бол критик хөдөлгүүр татгалзсан тохиолдолд хөөрөлтийн хийвэр траектор нь нислэгийн зам дахь бүх саад дээгүүр наад зах нь 50 футын босоо зайтай өнгөрч байх нөхцлийг хангах үүрэгтэй.
- б) Энэ бүлгийн (а)-ийн хүрээнд, хэрэв тухайн саад нь хөөрөлтийн хийсвэр траекторийн хүрээнд байгаа бол, агаарын хөлөг нисч өнгөрөх шугам болон саад хүртэлх хэвтээ зай нь дор зааснаас их байж болохгүй:
- 1) Хэрэв нислэгийн траекторыг  $15^{\circ}$ -аас илүү өнцгөөр өөрчлөх шаардлагагүй бол:
    - i. 45м нэмэх нь  $0,10D$ , дээд тал нь 600м хүртэл эсвэл, хэрэв АТГ эзэмшигч нь, ил харааны эсвэл радио навигацийн тусламжтай замаа олон нисэхэд туслах гарын авлага хэрэглэх журамтай бол, дээд тал нь 300м; эсвэл
    - ii. Өдрийн цагаар, ил харааны нөхцөлд бол, 30м нэмэх нь  $0,10D$  дээд тал нь 600м хүртэл эсвэл, хэрэв АТГ эзэмшигч нь, ил харааны эсвэл радио навигацийн тусламжтай замаа олон нисэхэд туслах гарын авлага хэрэглэх журамтай бол, дээд тал нь 300м;
  - 2) Хэрэв нислэгийн траекторыг  $15^{\circ}$ -аас илүү өнцгөөр өөрчлөх шаардлагатай бол:
    - i. 45м нэмэх нь  $0,10D$ , дээд тал нь 900м хүртэл эсвэл, хэрэв АТГ эзэмшигч нь, ил харааны эсвэл радио навигацийн тусламжтай замаа олон нисэхэд туслах гарын авлага хэрэглэх журамтай бол, дээд тал нь 600м; эсвэл
    - ii. Өдрийн цагаар, ил харааны нөхцөлд бол, 30м нэмэх нь  $0,10D$  дээд тал нь 600м хүртэл эсвэл, хэрэв АТГ эзэмшигч нь, ил харааны эсвэл радио навигацийн тусламжтай замаа олон нисэхэд туслах гарын авлага хэрэглэх журамтай бол, дээд тал нь 300м;
- с) Энэ бүлгийн (b)-д заасан  $D$  гэдэг нь, хөөрөлтийн боломжит дистанцийн төгсгөлөөс эхлэн агаарын хөлөг явж өнгөрөх хэвтээ зай гэж ойлгоно.



d) энэ бүлгийн (а)-ийн дагуу хөөрөлтийн хийсвэр траекторийг тооцохдоо АТГ эзэмшигч нь дараахь нөхцлийг бүрдүүлэх ёстой:

1) Дараахь нөхцлүүдийг тооцоондоо харгалзан үзнэ:

- i. Хөөрөхөөр гүйж эхлэх үеийн хөөрөлтийн жин; мөн
- ii. Аэродромын өндөр; мөн
- iii. Агаарын даралт, Олон улсын стандарт агаарын нөцлөөс 1%-аар өөрчлөгдөх бүр, аэродромын даралтын өндрийг; мөн
- iv. Аэродром дээрх гаднах агаарын хэм (температур); мөн
- v. Мэдээгээр өгсөн, өөдөөс үлээх салхины 50%-аас ихгүй хэсгийг эсвэл мэдээгээр өгсөн, арын салхины 150%-аас багагүй хэсгийг; мөн

2) Хөөрөлт үйлдэж байгаа гадаргуугаас дээш 50фут өндөр хүрэхээс өмнө ямар нэг эргэлт хийхгүй; мөн

3) Дарга эрх олгоогүй нөхцөлд:

- i. Хөөрөлт үйлдэж байгаа гадаргуугаас дээш 50фут өндөр хүрэхээс өмнө 15<sup>0</sup>-аас дээш хэмжээтэй ямар нэг крен хийхгүй; мөн
- ii. Хөөрөлт үйлдэж байгаа гадаргуугаас дээш өндөр 400м-тэй тэнцүү болон түүнээс доош өндөрт крен 20<sup>0</sup>-тай тэнцүү эсвэл түүнээс хэтрэхгүй байна; мөн
- iii. Хөөрөлт үйлдэж байгаа гадаргуугаас дээш өндөр 400м-тэй тэнцүү болон түүнээс дээш өндөрт, крен 25<sup>0</sup>-тай тэнцүү эсвэл түүнээс хэтрэхгүй байна; мөн

4) Дараахь нөхцлийг тооцохоор заасан байна:

- i. Ашиглалтын хурд болон нислэгийн траекторид крений үзүүлэх нөлөө; мөн
- ii. Ашиглалтын хурд нэмэгдэх тусам гүйлтийн дистанц ихэснэ; мөн
- iii. Өндөр авалтын градиент бууралт болон унах хурд хүртэлх нөөц хурдны хэмжээг ИНД-125.215-д заасны дагуу.

### **125.215 Хөдөлгүүр татгалзах – градиент болон унах хурдны засвар**

Өөр аргаар бодох боломжтой ашиглалтын өгөгдөхүүн байхгүй бол агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь, ИНД-125.213(d)(4)(iii)-ийн шаардлагыг

хангахын тулд Хүснэгт-2-ийг хэрэглэн өндөр авах градиент бууралтыг тооцох ба унах хурд хүртэлх нөөц хурд хэмжээг хадгалах ёстой.

#### Хүснэгт - 2

Крений өнцөг	Хурдны засвар	Градиентын засвар
15 <sup>0</sup> -аас 19 <sup>0</sup>	V <sub>2</sub>	1 х Агаарын хөлгийн ашиглалтын заавар 15 <sup>0</sup> градиент бууралт
20 <sup>0</sup> -аас 24 <sup>0</sup>	V <sub>2</sub> + 5knots	2 х Агаарын хөлгийн ашиглалтын заавар 15 <sup>0</sup> градиент бууралт
25 <sup>0</sup>	V <sub>2</sub> + 19knots	3 х Агаарын хөлгийн ашиглалтын заавар 15 <sup>0</sup> градиент бууралт

#### 125.217 Маршрутанд – критик хөдөлгүүр татгалзах

а) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь, ашиглаж байгаа 2 эсвэл түүнээс олон хөдөлгүүртэй агаарын хөлгийн хувьд агаарын хөлөг нь зохих аюулгүй доод өндөрт буюу түүнээс дээш өндөрт эерэг өнцгөөр нислэгийг үргэлжлүүлэх чадвартай байх нөхцлийг бүрдүүлэх ёстой ба аэродромоос дээш 1000фут өндөрт ашиглалтын өгөгдөхүүн нь дараахь шаардлагыг хангасан байна:

- 1) Тухайн нислэгийн цаг агаарын урьдчилсан мэдээний хүрээнд; мөн
- 2) Татгалзсан критик хөдөлгүүртэй; мөн
- 3) Үлдсэн хөдөлгүүрүүд нь максимум тасралтгүй горимоор ажиллана гэж тооцно.

б) гэрчилгээ эзэмшигч нь маршрутанд дахь хязгаарлалтыг энэхүү бүлгийн (а)-ийн шаардлагын дагуу тооцоолохдоо дараахь нөхцлийг хангах ёстой:

- 1) Агаарын хөлгийн ашиглалтын зааварт заасан максимум тасралтгүй горимоор бүх хөдөлгүүр нь ажиллаж 300 фут/мин-аас багагүй босоо хурдтайгаар өндөр авах боломжтой өндөрт эсвэл түүнээс дээш өндөрт агаарын хөлөг байгаа гэж тооцохгүй: мөн
- 2) Татгалзсан нэг хөдөлгүүртэй маршрутанд дахь өндөр авалтын градиент нь тухайн үеийн жин-градиент-хасах-0,5% градиент байна гэж тооцно.

#### 125.219 Маршрутанд – 90 минутын хязгаарлалт

а) АТГ эзэмшигч бүр өөрийн ашиглаж буй 2 хөдөлгүүртэй агаарын хөлөг бүр нь, буух үеийн жингээр тооцоолоход нислэгийн ашиглалтын зааварт заасан шаардлага

хангах зохих аэродром хүртэл 90 минут нисэх зайнаас хол зайд нисэхгүй байх нөхцлийг бүрдүүлэх ёстой.

- b) Энэхүү бүлгийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, АТГ эзэмшигч бүр өөрийн ашиглаж буй 3 болон түүнээс олон хөдөлгүүртэй агаарын хөлөг нь, буух үеийн жингээр тооцоолоход нислэгийн ашиглалтын зааварт заасан шаардлага хангах зохих аэродром хүртэл 90 минут нисэх зайнаас хол зайд нисэхгүй байх нөхцлийг бүрдүүлэх ёстой.
- c) АТГ эзэмшигч нь 3 болон түүнээс олон хөдөлгүүртэй агаарын хөлгөөр, буух үеийн жингээр тооцоолоход нислэгийн ашиглалтын зааварт заасан шаардлага хангах зохих аэродром хүртэл 90 минут нисэх зайнаас хол зайд нисэж болох ба ингэхдээ:
- 1) Хоёр хөдөлгүүр нэгэн зэрэг татгалзсан гэж хийсвэрээр тооцсон цэгээс, хүлээгдэж буй цаг уурын нөхцөлд татгалзсан хоёр хөдөлгүүртэйгээр тогтоосон журмыг ашиглан буулт үйлдэх боломжтой аэродром руу нислэгээ үргэлжлүүлэх нөхцлийг, хоёр хөдөлгүүр татгалзсан үеийн нислэгийн траекторын өгөгдөхүүн нь олгодог байна;
  - 2) Цаг агаарын нөхцлөөс шалтгаалан мөстөлт эсэргүүцэх системийг ашиглана гэж үзэн түүний нөлөөг тооцох бол нислэгийн хийсвэр траектор нь:
    - i. Нисэхээр төлөвлөсөн маршрутын дагуух минимум аюулгүй өндөрт эерэг (өгсөх) налуутай байх: эсвэл
    - ii. Энэхүү зүйлийн (d)-д зааснаас бусад тохиолдолд, маршрутын хамгийн эгзэгтэй цэгт хоёр хөдөлгүүр татгалзна гэвэл, тухайн үеийн жин-градиент, хасах, 0.5% градиент гэж тооцон, замын дагуух 10NM доторх бүх газар нутгийн өндөрлөг болон саадаас дээш наад зах нь 2000 фут зайтай өнгөрөхөөр байна;
  - 3) Хоёр хөдөлгүүр татгалзсаны дараа буухаар тооцсон аэродромоос дээш 1500 фут өндөрт нислэгийн хийсвэр траектор нь эерэг (өгсөх) налуутай байна; мөн
  - 4) Хоёр хөдөлгүүр татгалзна гэж хийсвэрээр тооцсон цэг дээрх агаарын хөлгийн жин нь, бууна гэж тооцсон аэродром хүртэл нисэхэд хангалттай, мөн дээр нь тухайн аэродром дээр наад зах нь 1500 фут өндөртэй очин дараа нь, дор хаяж 15 минут чиг шулуун нисэхэд хүрэлцэх хэмжээний түлшийг оруулан тооцсон жингээс бага байх ёсгүй.

- d) Хэрэв нисгэгч радио навигацийн төхөөрөмж ашиглан, нисэх замаараа 5NM-ийн нарийвчлалтай нисэх боломжтой бол энэхүү бүлгийн (с)(2)(ii)-д шаардсан 10NM-ийг 5NM болгон багасгаж болно.
- e) Энэхүү бүлгийн (с)-ийн шаардлагын дагуу тооцоог хийхдээ, агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь, буух үеийн жинд тохирох ашиглалтын өгөгдөхүүний шаардлага хангасан аэродром хүртэл бүх хөдөлгүүрийн аяллын нислэгийн хурдаар салхигүй нөхцөлд 90минут нисэх зайнаас хол зайд байгаа үеийн маршрутын хамгийн эгзэгтэй хэсэгт хоёр хөдөлгүүр зэрэг татгалзна гэж хийсвэрлэн тооцох ёстой.

#### **125.221 Буултын-өндөр авалт – Очих газар болон бэлтгэл аэродром**

Гэрчилгээ эзэмшигчийн агаарын хөлгүүд нь дараахь шаардлагыг хангасан байх ёстой:

- 1) Очих болон бэлтгэл аэродромын өндөр ба буух үед гаднах агаарын температур ямар байхыг заавал харгалзан буултын оролт болон буултын-өндөр авалтын жинг тооцох ба энэ нь буултын жингээс их байх ёсгүй; мөн
- 2) Шийдвэр гаргах өндөр нь 200фут-ээс бага ХНД-ийн буултын оролтын үед, буултын оролтын кофигурацитай байхад критик хөдөлгүүр татгалзна гэж үзвэл, хөөрөх жин болон нислэгт зарцуулах түлшний хэмжээ зэргийг харгалзан гаргасан буултын оролтын жинтэй үеийн хоёрдугаар хайцагт явах өндөр авалтын хийсвар траекторийн градиент нь:
  - i. Наад зах нь 2,5%; эсвэл
  - ii. Наад зах нь хоёрдугаар хайрцагт явах нислэгийн шулуун нь ИНД-125.213-ийн шаардлагын дагуу замын дагуух бүх саадаас дээгүүр өнгөрөхөөр хийсвэр траектор-өндөр авалтын гардиенттай байна.

#### **125.223 Буултын дистанц – Хуурай ХБЗ**

- a) Агаарын хөлөг бүрийн буух үеийн жин нь агаарын хөлгийн ашиглалтын зааварт заасан буултын жингийн хязгаарлалтаас хэтрэхгүйгээр үйл ажиллагаа явуулах нөхцлийг АТГ эзэмшигч бүр бүрдүүлэх ёстой.
- b) Очих аэродром болон аль нэг бэлтгэл аэродромд буух үе дэхь агаарын хөлгийн буултын бодит жин нь, зурвасны босгоос дээш 50фут-ээс бүрэн зогсолт бүхий буулт үйлдэх боломжтой хэмжээнд байх ба ингэхдээ дараахь шаардлагыг хангах нөхцлийг АТГ эзэмшигч бүр бүрдүүлэх ёстой:

- 1) Максимум хөөрөлтийн жин нь 5700кг болон түүнээс бага агаарын хөлгийн хувьд, зурвасны босгоноос дээш 50 фут өндрөөс эхлэн бүрэн зогсох хүртлээ буултын боломжит дистанцийн 85%-ийг, яван зогсох боломжтой байна; мөн
  - 2) Максимум хөөрөлтийн жин нь 5700кг-аас их агаарын хөлгийн хувьд, зурвасны босгоноос дээш 50 фут өндрөөс эхлэн бүрэн зогсох хүртлээ буултын боломжит дистанцийн 70%-ийг яван зогсох боломжтой байна.
- с) Энэхүү бүлгийн (b)-ийн дагуу буултын жинг тооцохдоо, АТГ эзэмшигч бүр нь дараахь нөхцлүүдийг харгалзах ёстой:
- 1) Аэродромын өндөр; мөн
  - 2) Аэродромын гаднах агаарын температур; мөн
  - 3) ХБЗ-ны төрөл болон гадаргуугын байдал; мөн
  - 4) ХБЗ-ны налуу болон суух чиглэл; мөн
  - 5) Мэдээгээр өгөгдсөн, өөдөөс үлээх салхины бүрдүүлэх хэсгийн **50-аас ихгүй** хувийг эсвэл араас үлээх салхины бүрдүүлэх хэсгийн **150-аас багагүй** хувийг тус тус тооцно.
- d) Энэхүү зүйлийн (b) болон (c)-д заасны дагуу агаарын хөлгийн буултыг диспетчерлэхдээ, агаарын хөлөг хамгийн тохиромжтой ХБЗ дээр газардна гэж үзэн дараахь нөхцлийг тооцно:
- 1) Урьдчилсан цаг агаарын нөхцөл; мөн
  - 2) Хүрээлэн буй өндөрлөгүүд; мөн
  - 3) Буулт болон оролтын тоног төхөөрөмжүүд; мөн
  - 4) Хоёрдугаар хайцагт явах нислэгийн зам дахь саад болон өндөрлөгүүд.
- e) Хэрэв АТГ эзэмшигч нь энэхүү зүйлийн (d)-д заасан очих аэродромын талаарх шаардлагыг хангах боломжгүй бол, энэхүү зүйлийн (a), (b) болон (c)-ийн шаардлага хангасан бэлтгэл аэродромыг сонгосон тохиолдолд агаарын хөлгийг диспетчерлэж болно.

### **125.225 Буултын дистанц – нойтон болон тундастай ХБЗ**

- a) АТГ бүр нь, агаарын хөлөг бүрийн хувьд дараахь шаардлагыг ханган нислэгийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх ёстой:

- 1) Хэрэв цаг агаарын урьдчилсан болон бодит мэдээгээр, эсвэл тэдгээрийг нийлүүлсэн мэдээгээр буух үед ХБЗ нь нойтон байж магадгүй бол, буултын боломжит дистанцийг тооцохдоо, ИНД-125.223-д заасан буултын дистанцийн наад зах нь 115% байхаар тооцно.
- 2) Хэрэв цаг агаарын урьдчилсан болон бодит мэдээгээр, эсвэл тэдгээрийг нийлүүлсэн мэдээгээр буух үед ХБЗ дээр тундас тогтсон байж магадгүй бол, буултын боломжит дистанцийг тооцохдоо наад зах нь:
  - i. Буултын дистанц нь энэхүү зүйлийн (а)(1)-ийн шаардлагад нийцэж байх; эсвэл
  - ii. Буултын дистанцийг тундастай зурвасанд буух өгөгдөхүүн ашиглан тодорхойлсон байна.
- b) Хэрэв нойтон зурвасны өгөгдөхүүнийг ашиглан тооцоог гаргахад, энэхүү зүйлийн (а)(1)-д шаардснаас нойтон зурвасны буултын дистанц нь богино байгаа боловч ИНД-125.223-д зааснаас урт байгаа тохиолдолд тэрхүү богино буултын дистанцийг ашиглаж болно.

#### **125.227 Огцом оролт болон түүнчлэн буулт үйлдэх аргачлал**

Хэрэв дараахь шаардлагыг хангасан бол АТГ эзэмшигч нь, аэродромоос дээш 50футаас нам боловч 35фут-ээс багагүй өндрөөс, 4,5<sup>0</sup> буюу түүнээс их өнцгөөр буултын огцом оролт үйлдэх журам ашиглаж болно:

- 1) Буултын огцом оролт хийх тухай, агаарын хөлгийн ашиглалтын зааварт тодорхой шаардлагуудыг заасан тухайлвал буултын оролтын хамгийн их өнцөг, аливаа бусад хязгаарлалт, онцгой тохиолдолын үеийнхийг оролцуулсан бүх журмууд мөн түүнчлэн зурвасны уртыг хэрхэн тооцох тухай; мөн
- 2) ХНД-ийн нислэгийн хувьд, огцом оролтоор буулт үйлдэх гэж байгаа зурвасны буултын оролтын систем нь, наад зах нь оролтын налууг заагч гэрлэн төхөөрөмжөөр давхар тоноглогдсон байна; мөн
- 3) ХНД-ийн нислэгийн хувьд, огцом оролтоор буулт үйлдэх зурвас болгоноор эрх олгон баталгаажуулж цаг агаарын минимумыг нь зааж өгсөн байна; мөн
- 4) ХНД-ийн нислэгийн хувьд, дараахь зүйлсийг анхаарах ёстой:
  - i. Сад болон өндөрлөгүүд; мөн
  - ii. Оролтын налууг заагч төхөөрөмжийн өгөгдөхүүний төрөл болон зурвасны байрлал тодорхойлоход хэрэглэгдэх ил харааны тоноглолууд, MLS; GPS; ILS; LOC; VOR; болон NDB; мөн

- iii. ДН болон MDA дээр ил хараагаар наад зах нь харсан байх шаардлагатай зүйлс; мөн
- iv. Агаарт хэрэглэгдэх төхөөрөмжүүд; мөн
- v. Нисгэгч нь тухайн аэродромтай танилцах нислэг үйлдэж зохих эрх авсан байна; мөн
- vi. Агаарын хөлгийн нислэгийн зааварт заасан журмууд болон хязгаарлалтууд; мөн
- vii. 2-р хайрцагт явахад тавигдах шаардлага болон нөхцлүүд.

### **125.228 FAR-23-аар гэрчилгээжсэн богино зайн (орон нутгын) агаарын хөлөг болон SFAR-41-ээр гэрчилгээжсэн агаарын хөлөг**

ИНД-125.229-өөс ИНД-125.235-ыг оролцуулан бүх шаардлагууд нь, FAR-23-аар гэрчилгээжсэн богино зайн (орон нутгын) агаарын хөлөг болон SFAR-41-ээр гэрчилгээжсэн агаарын хөлөг ашиглан үл ажиллагаа явуулж байгаа АТГ эзэмшигч нарт хамаарна.

### **125.229 Хөөрөлтийн дистанц**

- a) АТГ нь, агаарын хөлгийн ашиглалтын зааварт заасан, хөөрөлтийн хамгийн их жинг хэтрүүлэх ёсгүй.
- b) Энэхүү зүйлийн (a)-ийн хүрээнд, максимум хөөрөлтийн жинг бодохдоо АТГ эзэмшигч нь,  $V_{EF}$  хурд дээр критик хөдөлгүүр татгалзна хэмээн хийсвэрээр тооцож дараахь нөхцлийг хангах ёстой:
  - 1) Хурдатгалыг зогсоход шаардагдах дистанц */required accelerate-stop distance/* нь хурдатгалыг зогсоох */accelerate-stop/* дистанц эсвэл удааширсан хурдатгалын боломжит дистанцаас */accelerate slow distance available/* хэтэрч болохгүй; мөн
  - 2) Хөөрөлтөд шаардлагатай дистанц нь хөөрөлтийн боломжит дистанцаас хэтрэхгүй байна; мөн
  - 3) Хөөрөлтийн боломжит дистанцийг бүрдүүлж байгаа, ямарваа саадгүй замын */clearway/* хэсэг нь, хөөрөлтийн гүйлтийн уртын */take-off run/* хагасаас хэтрэхгүй байна; мөн

- 4)  $V_1$ -ийг үндэслэн хөөрөлтийг үргэлжлүүлэх мөн хөөрөлтийг зогсоох, аль ч тохиолдолд, хөөрөлтийн гүйлтийн урт нь хөөрөлтийн гүйлтийн боломжит уртаас хэтрэхгүй байна.
- с) Энэхүү зүйлийн (b)-ийн хүрээнд хөөрөлтийн максимум жинг бодохдоо АТГ эзэмшигч нь дараахь асуудлуудыг харгалзах ёстой:
- 1) Аэродромын өндөр; мөн
  - 2) Олон Улсын Стандарт Атмосферээс аэродромын даралт 1%-аар өөрчлөгдөх бүр аэродромын даралтын өндрийг шинээр тооцох; мөн
  - 3) Аэродромын гаднах агаарын температур; мөн
  - 4) ХБЗ-ын гадаргуугын төрөл, түүний нөхцөл байдал; мөн
  - 5) Хөөрөх чиглэл дэх ХБЗ-ын налуу; мөн
  - 6) Мэдээгээр өгөгдсөн, өөдөөс үлээх салхины бүрдүүлэх хэсгийн **50-аас ихгүй** хувийг эсвэл араас үлээх салхины бүрдүүлэх хэсгийн **150-аас багагүй** хувийг тус тус тооцно.

#### **125.231 Хөөрөлтөнд дэх нислэгийн хийсвэр траектор**

- а) АТГ эзэмшигч нь, критик хөдөлгүүр татгалзсан үед агаарын хөлөг нь хөөрөлтөнд нислэгийн хийсвэр траекторийн дагуух бүх өндөрлөг болон саадаас дээш дараахь зайг наад зах нь ханган давж байх нөхцлийг бүрдүүлэх ёстой:
- 1) Хөөрөлт үйлдэж байгаа агаарын хөлөг нь  $15^0$ -аас ихгүй крентэй эргэлт хийнэ гэж тооцсон тохиолдолд 35фут; мөн
  - 2) Хөөрөлт үйлдэж байгаа агаарын хөлөг нь  $15^0$ -аас их крентэй эргэлт хийнэ гэж тооцсон тохиолдолд 50фут.
- б) Энэхүү зүйлийн (a)-ийн хүрээнд, хэрэв өндөрлөг буй саадаас нислэгийн шугам хүртэлх зай доор зааснаас хэтрэхгүй байгаа бол тухайн саад буй өндөрлөгийг хөөрөлтийн траекторийн дагуу байгаа гэж тооцох ёстой:
- 1) Хэрэв нислэгийн траекторын дагуу нислэгийн замын чиглэлийг  $15^0$ -аас ихээр өөрчлөх шаардлагагүй бол:
    - i. 45м нэмэх нь 10D, дээд тал нь 600м, эсвэл хэрэв АТГ эзэмшигч нь ил харааны эсвэл радионавигаци хэрэглэн, явах ёстой замаараа явж байгаа эсэхээ нисгэгч хянах журам мөрддөг бол дээд тал нь 300м, эсвэл



- ii. Өдрийн цагаар ил харааны нөхцөлд бол, 30м нэмэх нь 0,10D дээд тал нь 600м эсвэл, хэрэв АТГ эзэмшигч нь ил харааны эсвэл радионавигаци хэрэглэн, явах ёстой замаараа явж байгаа эсэхээ нисгэгч хянах журам мөрддөг бол дээд тал нь 300м.
- 2) Хэрэв нислэгийн траекторын дагуу нислэгийн замын чиглэлийг 15<sup>0</sup>-аас ихээр өөрчлөх шаардлагатай бол:
- i. 45м нэмэх нь 10D, дээд тал нь 900м, эсвэл хэрэв АТГ эзэмшигч нь ил харааны эсвэл радионавигаци хэрэглэн, явах ёстой замаараа явж байгаа эсэхээ нисгэгч хянах журам мөрддөг бол дээд тал нь 600м, эсвэл
  - ii. Өдрийн цагаар ил харааны нөхцөлд бол, 30м нэмэх нь 0,10D дээд тал нь 600м эсвэл, хэрэв АТГ эзэмшигч нь ил харааны эсвэл радионавигаци хэрэглэн, явах ёстой замаараа явж байгаа эсэхээ нисгэгч хянах журам мөрддөг бол дээд тал нь 300м.
- c) Энэхүү зүйлийн (b) заалтын хувьд, D гэдэг нь хөөрөлтийн боломжит дистанцийн төгсгөлийн цэгээс хэвтээ хавтгайд агаарын хөлгийн туулах зай юм.
- d) Энэхүү бүлгийн (a)-ийн дагуу хөөрөлтийн үе дэхь нислэгийн хийсвэр траекторыг тооцохдоо, АТГ эзэмшигч нь дараахь нөхцлийг хангах ёстой:
- 1) Дараахь асуудлуудыг харгалзан үзэх ёстой:
    - i. Хөөрөхөөр гүйж эхлэх үеийн хөөрөлтийн бодит жин; мөн
    - ii. Аэродромын өндөр; мөн
    - iii. Атмосферын даралт олон улсын стандарт агаараас 1%-аар өөрчлөгдөх бүрт аэродромын даралтын өндрийг шинээр тооцох; мөн
    - iv. Аэродромын гаднах агаарын температур; мөн
    - v. Мэдээгээр өгсөн, өөдөөс үлээх салхины бүрдүүлэх хэсгийн **50-аас ихгүй** хувийг эсвэл араас үлээх салхины бүрдүүлэх хэсгийн **150-аас багагүй** хувийг тус тус тооцно.
  - 2) Хөөрөлт үйлдсэн гадаргуугаас дээш 50 фут өндөр хүртэл нислэгийн замыг өөрчлөхгүй; мөн
  - 3) ИНЕГ-ын дарга тусгайлан өөр зөвшөөрөл олгоогүй бол:
    - i. Хөөрөлт үйлдсэн гадаргуугаас (аэродромын түвшингээс) дээш 50 фут өндөр хүртэл 15<sup>0</sup>-аас их крен хийхгүй байх; мөн

- ii. Хөөрөлт үйлдсэн гадаргуугаас (аэродромын түвшингээс) дээш 400фут болон түүнээс доош өндөрт, 20<sup>0</sup>-аас их крен хийхгүй байх; мөн
- iii. Хөөрөлт үйлдсэн гадаргуугаас (аэродромын түвшингээс) дээш 400футээс дээш өндөрт, 25<sup>0</sup>-аас их крен хийхгүй байх; мөн

4) Холбогдох тооцоог хийсан байна:

- i. Ашиглалтын хурд болон нислэгийн траекторт нөлөөлөх крений үзүүлэлтүүд; мөн
- ii. Ашиглалтын хурд ихэсэх тутамд дистанци хэрхэн ихэсэх; мөн
- iii. өндөр авалтын градиентын бууралт болон унах хурд хүртэлх хурдны нөөцийг ИНД-125.125-ын дагуу тооцох.

#### **125.233 буултын дистанци – Хуурай зурвас**

- a) Агаарын хөлөг бүрийн буух үеийн жин нь агаарын хөлгийн ашиглалтын зааварт заасан буултын жингийн хязгаарлалтаас хэтрэхгүйгээр үйл ажиллагаа явуулах нөхцлийг АТГ эзэмшигч бүр бүрдүүлэх ёстой.
- b) Очих аэродром болон аль нэг бэлтгэл аэродромд буух үе дэхь агаарын хөлгийн буултын бодит жин нь, зурвасны босгоос дээш 50фут-ээс бүрэн зогсолт бүхий буулт үйлдэх боломжтой хэмжээнд байх ба ингэхдээ буултын дистанцийн 70%-ийг туулаад бүрэн зогсох нөхцлийг АТГ эзэмшигч бүр бүрдүүлэх ёстой.
- c)